БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## АУДИТЫН НЭР: БАЯНХОНГОР АЙМГИЙН ИТХ-ААС 2016-2020 ОНД БАТАЛСАН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2022/35-ШТА-ГА

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**
**Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
**Аудитын менежер А.Цээням**
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
**Ахлах аудитор Б.Должмаа**
Утас: 70442424 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn
**Аудитор Б.Нарангэрэл**
Утас: 70442424 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn

Баянхонгор хот 2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

## АГУУЛГА

**Товчилсон үгийн тайлбар** ..... 3
**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээлэл** ..... 4
**БҮЛЭГ 1. Аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрийг батлахдаа хэрэгцээ шаардлагыг үндэслэж, холбогдох бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.** ... 8
1.1. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг орон нутгийн хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна..... 8
1.2. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломжит үе шат, хугацаа, хариуцах эзэн, хамрах хүрээ, санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ зэргийг нарийвчлан төлөвлөөгүй байна. ..... 10
**БҮЛЭГ 2. Холбогдох төрийн байгууллагууд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүйгээс ИТХ-аас баталсан төсөл хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байна.** ..... 13
2.1. Зарим төсөл, хөтөлбөрийг батлахдаа хөтөлбөрийн шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүйгээс хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдсан эсэхийг тооцох боломжгүй байна. ..... 13
2.2.Баталсан төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийг журамд заасан хугацаанд аймгийн ИТХ-д иж бүрэн тайлагнаагүй байна. ..... 25
**БҮЛЭГ 3. Аймгийн ИТХ-аас 2017-2020 онд баталсан дэд хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэрэгжсэн нийт хугацааны байдлаар тооцож ажиллаагүй байна.** ..... 26
3.1. Аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. ..... 26
3.2. Зарим дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, үр дүнг тооцсон байгаа боловч журмын дагуу дууссан хөтөлбөрийн эцсийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийгээгүй байна. ..... 27
**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ** ..... 33
**ДҮГНЭЛТ:** ..... 34
**ЗӨВЛӨМЖ:** ..... 35
**ХАВСРАЛТУУД** ..... 36-48

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ХБТХОХ | Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ОНӨГ | Орон нутгийн өмчийн газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |

## Хүснэгтийн жагсаалт


| Хүснэгтийн дугаар | Хүснэгтийн тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Хүснэгт 1 | Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд | 6-7 |
| Хүснэгт 2 | Аймгийн дэд хөтөлбөрийн баталсан он | 8 |
| Хүснэгт 3 | Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд салбараар | 8 |
| Хүснэгт 4 | Төсөл хөтөлбөрийг олон нийтээр хэлэлцүүлсэн байдал | 10 |
| Хүснэгт 5 | Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв | 11-12 |
| Хүснэгт 6 | Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв, гүйцэтгэл | 15 |
| Хүснэгт 7 | Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв, гүйцэтгэл | 15 |
| Хүснэгт 8 | Аймгийн ИТХ-д хэрэгжилтийг тайлагнасан дэд хөтөлбөрүүдийн нэгтгэл | 25 |
| Хүснэгт 9 | Аймгийн ИТХ-д хэрэгжилтийг тайлагнасан дэд хөтөлбөрүүдийн нэгтгэл | 26 |
| Хүснэгт 10 | Баянхонгор аймгийн СХАА-аас хийсэн хяналт шалгалт | 27 |
| Хүснэгт 11 | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ | 28 |
| Хүснэгт 12 | Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ | 28-29 |


## Дүрслэлийн жагсаалт


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Дүрслэл 1 | Төсөл, хөтөлбөр, бодлогын баримт бичгийн уялдаа /тоогоор/ | 9 |
| Дүрслэл 2 | Аймгийн ИТХ-аас баталсан төсөл хөтөлбөр | 13 |


## Судалгааны жагсаалт


| № | Тайлбар | Хуудасны дугаар |
|---|---|---|
| Судалгаа 1 | Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байдал | 36-39 |
| Судалгаа 2 | Дэд хөтөлбөрүүдийг шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон байдал | 40-41 |
| Судалгаа 3 | Дэд хөтөлбөрүүдийн санхүүжилт /дэлгэрэнгүй/ | 42-43 |
| Судалгаа 4 | Нягтлан бодох бүртгэлд тусгасан хөрөнгө | 44 |
| Судалгаа 5 | Дэд хөтөлбөрийн санхүүжилт /орон нутгийн төсөв/ | 45-46 |
| Судалгаа 6 | Дэд хөтөлбөрүүдийн хамрах хугацаа | 47-48 |

| | Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл |
|---|---|
| **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх** | Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/12 дугаар тушаалаар баталсан аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газруудаас гүйцэтгэх аудитын сэдэв, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалаар баталсан "Аудитын төлөвлөгөө батлах тухай" тушаалыг үндэслэн хийв. |
| **Аудитын зорилт** | Баянхонгор аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.<br>Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийв. Үүнд:<br>-Төсөл, хөтөлбөрийг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагад үндэслэсэн эсэх<br>-ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөрийн зорилт хангагдсан эсэх<br>-ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцсон эсэх |
| **Аудитын хамарсан хүрээ** | Аудитыг ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, төлөвлөгөө, тайлан, олгосон санхүүжилт, аймгийн ИТХ, ЗДТГ болон холбогдох байгууллагаас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн ажлын тайланг үндэслэн гүйцэтгэв.<br>Аудитад 2016-2020 онд аймгийн ИТХ-аас хэрэгжүүлэхээр баталсан төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал болон аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар болон бусад байгууллагуудын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит" стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "ТАБ-аас аудит хийх журам", 2022 оны А/67 дугаар тушаалаар баталсан "Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал", "Гүйцэтгэлийн аудит хийх аргачлал"-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав. |
| **Аудитын бүрэлдэхүүн хугацаа** | Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цэеням аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт тавьж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Нарангэрэл нар баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, хуваарийн дагуу гүйцэтгэв. |

| | |
|---|---|
| | Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатанд холбогдох газруудаас ирүүлсэн судалгааг 2022 оны 8 дугаар сарын 25-нд нэгтгэн, аудитын төлөвлөгөөг 2022 оны 9 дүгээр сарын 26-нд батлуулж, талбарын ажлыг 2022 оны 9 дүгээр сарын 27-ний өдрөөс 10 дугаар сарын 14-ний өдрийн хугацаанд гүйцэтгэх ба тайлагналын үе шатны ажлыг 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлүүлэн аудитын тайланг 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр байгууллагын Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлэв. |
| **Хүндрэл бэрхшээл** | Баталсан төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлтийн үйл ажиллагааны холбогдох баримтуудыг байхгүй гэсэн шалтгаанаар аудитад шаардлагатай баримт материалуудыг ирүүлээгүй нь хүндрэл учирсан болно. |

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр анх баталсан бөгөөд УИХ-аас 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр тус хуулийг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль болгон шинэчлэн найруулж баталсан байна.

Аудитын хамрах хугацаанд 2015 онд баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль хамрах бөгөөд тус хууль нь Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлогын төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх гэсэн үндсэн зорилттой байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад зааснаар “Хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичиг гэж тодорхойлжээ.

Аймгийн Засаг даргын тамгын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газраас ирүүлсэн судалгааг нэгтгэхэд аймгийн ИТХ-аас 2016-2020 онд дунд болон богино хугацаанд мөрдөх нийт 34 бодлогын баримт бичгийг баталсан байна.

*Хүснэгт 1. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд*

| № | Төсөл хөтөлбөрийн нэр | Хэрэгжүүлэгч байгууллага | Хэрэгжүүлэх хугацаа | Баталсан огноо | Тогтоолын дугаар | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | ХБТХОХ, БОАЖГ | 2017-2020 | 2017.11.29 | 146 | 902.3 | 902.1 |
| 2 | Амар тайван амьдрал | ХЭЗХ, ЦГ, | 2017-2020 | 2017.01.03 | 1 | 128.7 | 127.7 |
| 3 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | ХЭЗХ, ТАТ | 2020-2024 | 2020.02.01 | | - | - |
| 4 | Ахмадаа ачилья | НБХ, Ахмадын хороо | 2017-2021 | 2017.11.29 | 142 | 13.0 | 13.0 |
| 5 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | ХБТХОХ, БОАЖГ | 2018-2023 | 2018.03.05 | 1-Oct | - | - |
| 6 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | ХБТХОХ, ХХААГ | 2019.01.31 | 2019.01.31 | 16 | 2,514.0 | 2,314.0 |
| 7 | Баянхонгор робокон | НБХ, БШУГ | 2017-2020 | 2017.07.17 | 105 | 5.0 | 2.1 |
| 8 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | НХБ, ЭМГ | 2017-2020 | 2017.11.29 | 145 | 10.0 | 6.1 |
| 9 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | ХЭЗХ, ЦГ, ГБХЗХГ | 2022-2023 | 2020.08.26 | 71 | 14.7 | 14.7 |
| 10 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | НБХ, ГБХЗХГ | 2018-2022 | 2019.12.25 | 145 | 8.0 | 7.6 |
| 11 | Залуучуудын хөгжлийг дэмжих | НБХ, ХХҮГ | 2017-2020 | 2018.09.19 | 106 | 9.8 | 9.4 |
| 12 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам | ХЭЗХ, ЦГ | 2017-2020 | 2018.09.19 | 106 | 40.0 | 40.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | | | | | | |
| 13 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | НБХ | 2018-2020 | 2018.07.07 | 81 | 278.6 | 278.4 |
| 14 | Илгээлтийн эзэн | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2020 | 2017.05.16 | 75 | 1,265.0 | 1,265.0 |
| 15 | Сайн багш | НБХ, БШУГ | 2017-2020 | 2017.07.17 | 106 | 40.0 | 36.8 |
| 16 | Соёлын ажилтан | НБХ, БШУГ | 2017-2020 | 2017.07.17 | 104 | 91.9 | 91.8 |
| 17 | Торгон сүрэг | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2020 он, 2020-2025 он | 2017.05.16 | 76 | 99.4 | 99.4 |
| 18 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | ХЭЗХ, ТАТ | 2018-2020 | 2018.09.19 | 91 | 1,751.5 | 1,751.5 |
| 19 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | НХБ, ЭМГ | 2017-2021 он, 2022-2026 он | 2017.11.29 | 144 | 17,064.6 | 17,064.0 |
| 20 | Тунгалаг санхүү | СТХС | 2018-2020 | 2019.03.19 | 23 | 19.0 | 18.6 |
| 21 | Ухаалаг Баянхонгор | ТЗУХ | 2017-2020 | 2019.01.31 | 2 | 378.0 | 350.0 |
| 22 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | НБХ, БТСГ | 2017-2020 | 2017.11.29 | 140 | 679.1 | 679.1 |
| 23 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | НХБ, ЭМГ | 2018-2021 | 2018.12.05 | 127 | 1,360.0 | 1,360.0 |
| 24 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | ХБТХОХ, ХХААГ | 2020-2024 | 2020.09.14 | 90 | 90.0 | 90.0 |
| 25 | Хос бичигтэн | НБХ, БШУГ | 2017-2020 | 2017.07.17 | 107 | 5.0 | 5.0 |
| 26 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2021 | 2017.01.18 | 13 | 10.0 | - |
| 27 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | НБХ, ХХҮГ | 2018-2020 | 2018.07.07 | 82 | 16.0 | 15.8 |
| 28 | Хуримтлалтай хонгорчууд | СТСХ, ДЗОУБ | 2020-2024 | 2020.07.31 | 59 | 32.5 | 12.9 |
| 29 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | НБХ, ГБХЗХГ | 2017-2021 | 2018.05.02 | 37 | 615.4 | 612.4 |
| 30 | Цахим архив Баянхонгор | ХЭЗХ, ТАТ | 2020-2024 | 2017.01.03 | 2 | 70.0 | 70.0 |
| 31 | Элэг бүтэн-Баянхонгор | НХБ, ЭМГ | 2017-2020 | 2017.11.29 | 143 | 283.5 | 283.5 |
| 32 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | НХБ, ЭМГ | 2017-2021 | 2017.11.29 | 141 | 17.0 | 14.2 |
| 33 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | НХБ, ЭМГ | 2017-2020 | 2017.09.07 | 121 | 40.0 | 33.6 |
| 34 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | ХБТХОХ, ЭХЗЗ | 2019-2020 | 2019.03.19 | 22 | - | - |
| | Дүн | | | | | 27,851.9 | 27,568.8 |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс ирүүлсэн санхүүжилтийн мэдээлэл*

Дээрх 34 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн болон улсын төсөв, олон улсын хандив тусламжийн эх үүсвэрээс нийт 27,851.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 27,568.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-аас баталсан 34 дэд хөтөлбөрийн 17 дэд хөтөлбөрийг 2017 онд баталсан ба дэд хөтөлбөрийг салбараар нь авч үзвэл нийгмийн халамжийн болон хууль эрх зүйн салбарт тус бүр 7 дэд хөтөлбөр баталсан нь нийт дэд хөтөлбөрийн 41.2 хувийг эзэлсэн бөгөөд дээрх хөтөлбөрөөс 21 дэд хөтөлбөр нь 2020 онд хэрэгжиж дууссан ба 13 дэд хөтөлбөрийн хугацаа дуусаагүй хэрэгжиж байна.

УИХ-аас 2020 онд шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар дэд хөтөлбөрүүдийг баталж, хэрэгжүүлэх тухай заагаагүй бөгөөд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.1-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх” гэж заажээ.

# АУДИТЫН ДҮН

## БҮЛЭГ 1. Аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрийг батлахдаа хэрэгцээ шаардлагыг үндэслэж, холбогдох бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

### 1.1. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийг орон нутгийн хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байна.

1.1.1. Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд дунд болон богино хугацаанд мөрдөгдөх нийт 34 дэд хөтөлбөрийг батaлж холбогдох салбар, байгууллагуудад хэрэгжүүлэхийг даалгасан ба 2022 оны 8 дугаар сарын байдлаар 21 дэд хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2020 онд дуусаж, 13 дэд хөтөлбөрийн хугацаа дуусаагүй хэрэгжиж байна.

*Хүснэгт 2. Аймгийн дэд хөтөлбөрийн баталсан он*

| № | Баталсан төсөл хөтөлбөрийн | | Үүнээс | |
|---|---|---|---|---|
| | Он | Тоо | 2016-2020 онд хэрэгжиж дууссан | Одоо хэрэгжиж байгаа |
| 1 | 2016 | - | - | - |
| 2 | 2017 | 17 | 13 | 4 |
| 3 | 2018 | 8 | 5 | 3 |
| 4 | 2019 | 5 | 3 | 2 |
| 5 | 2020 | 4 | 0 | 4 |
| Нийт | | 34 | 21 | 13 |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолууд*

Аймгийн ИТХ-аас баталсан 34 дэд хөтөлбөрийн 50 хувь буюу 17 дэд хөтөлбөрийг 2017 онд баталсан ба дэд хөтөлбөрийг салбараар нь авч үзвэл нийгмийн халамжийн болон хууль эрх зүйн салбарт тус бүр 7 дэд хөтөлбөр баталсан нь нийт дэд хөтөлбөрийн 41.2 хувийг эзэлсэн байна.

*Хүснэгт 3. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд салбараар*

| № | Салбараар | Дэд хөтөлбөрийн тоо | Эзлэх хувийн жин |
|---|---|---|---|
| 1 | Боловсрол | 4 | 11.8% |
| 2 | Эрүүл мэнд | 5 | 14.7% |
| 3 | Хууль эрх зүй | 7 | 20.6% |
| 4 | Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин | 4 | 11.8% |
| 5 | Соёл урлаг, спорт | 3 | 8.8% |
| 6 | Нийгмийн халамж | 7 | 20.6% |
| 7 | Эдийн засаг, үйлдвэржилт | 4 | 11.8% |
| ДҮН | | 34 | 100.0% |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолууд*

“Хуримтлалтай хонгорчууд”, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III”-ийн төсөл хөтөлбөр боловсруулах салбар хороог аймгийн Засаг даргын 2020 оны А/90 дүгээр захирамжаар байгуулан төлөвлөгөө гарган ажилласан байна.

Харин бусад төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, урьдчилсан судалгаа шинжилгээ хийсэн эсэх талаар ажлын баримт материалууд холбогдох газруудад байхгүй байна.

Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4[1]-т заасан зарчмыг хангаагүй, Засгийн газрын 2016 оны 249 дугаар тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 3[2] дахь хэсгийг зөрчсөн байна.

Иймд цаашид Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8[3]-т нийцүүлэн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж, ажлын баримт материалыг холбогдох байгууллагын архивд хүлээлгэн өгч баримтжуулж, түүнд хяналт тавьж ажиллах нь зүйтэй байна.

1.1.2.Аймгийн ИТХ-аас баталсан 34 төсөл хөтөлбөрийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичиг болох Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн эсэхийг аудитаар шалгахад 21 хөтөлбөрийг дээрх бодлогын баримт бичгүүдтэй, 10 хөтөлбөрийг үндэсний хөтөлбөртэй уялдуулан төлөвлөсөн байгаа бол 3 хөтөлбөрийг холбогдох хуулийн заалттай нийцүүлэн төлөвлөсөн байна. */ХавсралтNo1/*




1.1.3. Аймгийн дэд хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэд олон нийтээс санал авсан талаарх холбогдох баримт материал байхгүй байгаа нь Засгийн газрын 2016 оны 249 тоот тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 18.6[4] дахь заалтыг зөрчсөн байна.

Харин аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс ирүүлсэн "Хүүхдэд ээлтэй орон нутаг" аймгийн дэд хөтөлбөрийн олон нийтэд хэлэлцүүлэг хийсэн тухай баримт материалтай танилцахад уг хөтөлбөрийг Баянхонгор сумын 5 баг, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон Галуут, Жинст сумдын иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж төлөвлөсөн байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангаас хэлтсээс 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн албан бичгээр "Хуримтлалтай хонгорчууд" дэд хөтөлбөрийн төслийг боловсруулахдаа 1016 иргэнээс цаасан болон цахим хэлбэрээр санал

[1] *судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;*
[2] *Төсөл боловсруулах төлөвлөгөө*
[3] *судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;*
[4] *хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах.*

асуулга авч хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай нотлох баримтыг ирүүлсэн болно.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар дараах дэд хөтөлбөрүүдийг холбогдох салбар, байгууллага, иргэд олон нийтийн уулзалт зөвлөгөөн зэрэгт хэлэлцүүлж, санал авч баталсан тухай холбогдох материалуудыг төрийн аудитын байгууллагад ирүүлж байжээ. Үүнд:

*Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийг олон нийтээр хэлэлцүүлсэн байдал*

| Хөтөлбөрийн нэр | Тайлбар |
|---|---|
| “Хос бичигтэн”<br>“Робокон”<br>“Сайн багш” | “Боловсролын удирдах ажилтны сургалт”-ын үеэр 29 сургуулийн захирал, 39 цэцэрлэгийн эрхлэгч, 45 сургалтын менежерүүдэд танилцуулж, санал авсан. |
| “Соёлын ажилтан” | Аймгийн ХДТ-аас 7, Хүүхдийн Тэмүжин театраас 1, Түүх угсаатны зүйн музейгээс 5, Нийтийн номын сангаас 14 санал ирснийг харгалзан дэд хөтөлбөрийг боловсруулсан байна. Дэд хөтөлбөрийн төслийг 2017 оны 07 дугаар сарын 07-ний өдөр аймгийн ХДТ-т аймгийн соёлын байгууллагын ажилтнуудад танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан байна. |
| “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” | Аймгийн аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд, өрхийн эрүүл мэндийн төв болон аймгийн Эрүүл мэндийн газрын ажилтнуудад танилцуулж, саналыг авсан. Мөн сум дундын эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төвүүдэд хөтөлбөрийн төслийг цахимаар хүргүүлж, ажиллагсдаар хэлэлцүүлж, саналаа ирүүлэхийг даалгасны дагуу 10 сумаас санал ирсэн. |

*Эх сурвалж: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-д 2017 онд хийсэн нийцлийн аудитын тайлан*

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар аймаг, сумын Засаг дарга нарт “Аймаг, сумын ИТХ-ын хуралдаанаар хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг батлуулахдаа журмын 31.1-31.7-д заасан хавсралтуудыг бэлтгэн хүргүүлж, ажлын хэсэг холбогдох баримт материал, хавсралтыг архивын нэгж болгон захиргааны байгууллагад хүлээлгэж өгөх” гэсэн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Гэвч дэд хөтөлбөрүүдийн төлөвлөлтийн үе шатны холбогдох баримт, материалуудыг байхгүй гэсэн шалтгаанаар аудитад ирүүлээгүй нь холбогдох төрийн байгууллагуудын тухай үед ажиллаж байсан алба хаагчид солигдсон, ажил хариуцсан албан тушаалтнуудын ажлын хариуцлагагүй байдлаас төрийн залгамж чанар алдагдсаныг харуулж байна.

### 1.2. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломжит үе шат, хугацаа, хариуцах эзэн, хамрах хүрээ, санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ зэргийг нарийвчлан төлөвлөөгүй байна.

1.2.1. Аймгийн хэмжээнд баталсан дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг дэд хөтөлбөрт тооцоолоогүй, зарим дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг урьдчилан тооцоолж хөтөлбөрт тусгаагүй байгаа нь Засгийн газрын

2016 оны 249 тоот тогтоолоор баталсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-ын 15[5] дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

***Аудитын илрүүлэлт:***

- *"Залуучуудын хөгжлийг дэмжих" хөтөлбөр*
- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөр*
- *"Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх" хөтөлбөр*
- *"Эрүүл мэндийн ажилтны хөгжил" хөтөлбөр*
- *"Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол" хөтөлбөр*
- *"Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах" хөтөлбөр*
- *"Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөр*
- *"Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх дунд хугацааны хөтөлбөр"*
- *"Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах" хөтөлбөр*
- *"Жендерийн эрх тэгш байдлыг хангах" хөтөлбөр*
- *"Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого" хөтөлбөр зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн тооцооллыг хийгээгүй байна.*

Иймд Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6[6]-т нийцүүлэн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичгийг төлөвлөж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.2.2.Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан 34 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 4,276.0 сая, улсын төсвөөс 22,634.4 сая, олон улсын байгууллага болон хандив тусламжийн эх үүсвэрээс 556.5 сая нийт 27,466.9 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдэд 2017 онд 768.3 сая, 2018 онд 1,033.8 сая, 2019 онд 973.6 сая, 2020 онд 1,500.3 сая, нийт 4,276.0 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төсөвт тусгаж баталсан байна.

*Хүснэгт 5. Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв /сая.төг/*

| № | Дэд хөтөлбөрийн нэр | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | 0 | 10 | 0 | 7 | 17.0 |
| 2 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | 0 | 0 | 0 | 32.2 | 32.2 |
| 3 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | 0 | 8 | 4 | 4 | 16.0 |
| 4 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | 0 | 10 | 0 | 0 | 10.0 |
| 5 | Соёлын ажилтан | 0 | 0 | 88.9 | 3 | 91.9 |
| 6 | Баянхонгор робокон | 0 | 0 | 0 | 5 | 5.0 |
| 7 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | 0 | 120 | 210.1 | 349.1 | 679.1 |
| 8 | Тунгалаг санхүү | 0 | 0 | 9.0 | 10 | 19.0 |
| 9 | Сайн багш | 0 | 10 | 20 | 10 | 40.0 |
| 10 | Торгон сүрэг | 49.4 | 50 | 0 | 0 | 99.4 |
| 11 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | 0 | 0 | 0 | 0 | - |
| 12 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 0 | 0 | 0 | 10 | 10.0 |
| 13 | Илгээлтийн эзэн | 90 | 100 | 100 | 100 | 390.0 |

[5] *Захиргааны байгууллага төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.*

[6] *нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх;*

| № | Дэд хөтөлбөрийн нэр | 2017 он | 2018 он | 2019 он | 2020 он | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 14 | Ахмадаа ачилья | 0 | 10 | 3 | 0 | 13.0 |
| 15 | Ухаалаг Баянхонгор | 0 | 1.9 | 376.0 | 0 | 377.9 |
| 16 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | 560 | 400 | 0 | 400 | 1,360.0 |
| 17 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | 0 | 0 | 0 | 0 | - |
| 18 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | 0 | 0 | 40 | 0 | 40.0 |
| 19 | Хос бичигтэн | 0 | 0 | 0 | 5 | 5.0 |
| 20 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | 0 | 14.7 | 0 | 0 | 14.7 |
| 21 | Залуучуудын хөгжлийг дэмжих | 0 | 0 | 4.78 | 5 | 9.8 |
| 22 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | 0 | 10 | 15 | 15 | 40.0 |
| 23 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | 0 | 0 | 0 | 19 | 19.0 |
| 24 | Элэг бүтэн-Баянхонгор | 0 | 0 | 20 | 0 | 20.0 |
| 25 | Цахим архив Баянхонгор | 0 | 70 | 0 | 0 | 70.0 |
| 26 | Хуримтлалтай хонгорчууд | 0 | 7.5 | 0 | 25 | 32.5 |
| 27 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | 34 | 120.7 | 89.9 | 120 | 364.6 |
| 28 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | 0 | 70 | 308.5 | 273.8 | 652.3 |
| 29 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | 0 | 6 | 0 | 29.97 | 36.0 |
| 30 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | 0 | 0 | 60.0 | 0 | 60.0 |
| 31 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | 0 | 0 | 0 | 0 | - |
| 32 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | 0 | 0 | 0 | 0 | - |
| 33 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | 0 | 5 | 0 | 3 | 8.0 |
| 34 | Амар тайван амьдрал | 34.9 | 9.99 | 9.5 | 74.3 | 128.7 |
| | ДҮН | 768.3 | 1,033.8 | 1,358.6 | 1,500.3 | 4,661.0 |

*Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс ирүүлсэн мэдээлэл*

"Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг", "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III", "Эрчим хүчний хэмнэлтийн бодлого" дэд хөтөлбөрүүдэд тус онуудад орон нутгаас төсөв хуваарилаагүй байна.

Харин "Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх" дэд хөтөлбөр нь 2020 оны 12 дугаар сард батлагдсан тул аудитад хамрагдах онд төсөв хуваарилагдаагүй байна.

1.2.3. Аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрийг батлахдаа хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган, биелэлтийг тайлагнаж байхыг аймгийн Засаг даргад даалгасны дагуу аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс 2020 онд батлагдсан "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-III", "Ногоон хөгжлийн хэтийн зорилт", Нийгмийн бодлогын хэлтсээс "Сайн багш" "Баянхонгор робокон", "Хос бичигтэн" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталсан байна.

Харин бусад дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аудитын явцад холбогдох байгууллагуудаас ирүүлээгүй бөгөөд энэ талаар аймгийн ЗДТГ-ын НБХ-ийн ахлах мэргэжилтнээс тодруулахад:

“Төсөл, хөтөлбөрийг хариуцаж хэрэгжүүлэх байгууллага нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж биелэлтийг тайлагнадаг” гэсэн тайлбарыг өгсөн нь аймгийн ИТХ-ын тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**БҮЛЭГ 2. Холбогдох төрийн байгууллагууд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулаагүйгээс ИТХ-аас баталсан төсөл хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байна.**

**2.1. Зарим төсөл, хөтөлбөрийг батлахдаа хөтөлбөрийн шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүйгээс хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдсан эсэхийг тооцох боломжгүй байна.**

2.1.1.Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр зорилт тус бүрээр гарган тайлагнаж байгаа ч хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх боломжит үе шат, хугацаа, хариуцах эзэн, хамрах хүрээ, санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ зэргийг нарийвчлан төлөвлөөгүйгээс зорилтууд хугацаандаа бүрэн хэрэгжиж хөтөлбөрийн үр дүн гарах боломж хангагдаагүй байна.

Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан 34 төсөл хөтөлбөрөөс “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр 3” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/126 дугаар захирамжаар баталсан байгаа ч бусад дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан эсэх талаар нотлох баримтыг аудитаар ирүүлээгүй болно.

2.1.2.Аймгийн ИТХ-аас хэрэгжүүлэхээр баталсан зарим төсөл хөтөлбөр нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй, зарим төсөл хөтөлбөрийн биелэлтийг тооцож гаргаагүй байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд 2016-2020 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдээс 9 төсөл хөтөлбөр нь шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон ч зорилтод түвшиндээ хүрээгүй, 2 төсөл хөтөлбөрийн биелэлтийн тайланг гаргасан байгаа ч шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тооцоогүй, 10 хөтөлбөрийг батлахдаа хөтөлбөрийн шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүйгээс хөтөлбөрийн зорилт

Дүрслэл 2. Аймгийн ИТХ-аас баталсан төсөл хөтөлбөр



бүрэн хангагдсан эсэхийг тооцох боломжгүй байна. Мөн 2 дэд хөтөлбөр нь биелэлтийг тооцох хугацаа болоогүй байна. /Хавсралт2/

Шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон ч зорилтод түвшиндээ хүрээгүй төсөл хөтөлбөрүүдийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийг аудитаар дахин тооцож үзэхэд 43.1-76.3 хувийн хэрэгжилттэй байна. /Хавсралт №2/

Дээрх төсөл, хөтөлбөрүүд нь хугацаандаа бүрэн хэрэгжээгүй байгаа нь Монгол улсад Ковид-19 цар тахал тархаж хөл хорио тогтоон, олон нийтийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

***Аудитын илрүүлэлт:***

- *"Залуучуудын хөгжлийг дэмжих" хөтөлбөр 69.9%-тай хэрэгжсэн;*
- *."Эрүүл мэндийн ажилтны хөгжил" хөтөлбөр 48.9% тай хэрэгжсэн*
- *"Элэг бүтэн Баянхонгор" хөтөлбөр 53.4% тай хэрэгжсэн*
- *"Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол" хөтөлбөр 43.1%-тай хэрэгжсэн*
- *"Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" дэд хөтөлбөр 50.7%-тай хэрэгжсэн*
- *"Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөр 76.3%-тай хэрэгжсэн*
- *"Жендерийн эрх тэгш байдлыг хангах" хөтөлбөр 59.8%-тай хэрэгжсэн*
- *“Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” дэд хөтөлбөр нь 63%-тай хэрэгжсэн байна.*

Иймд цаашид аймгийн ИТХ-аас баталсан төсөл, хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг гаргаж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

“Жендерийн эрх тэгш байдлыг хангах” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд “Нийгмийн түншлэлийн сүлжээ”, “Жендэр Согоовор Арвай”, “Хонгор нутгийн үрс” төрийн бус байгууллагуудаас 2020 онд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байна.

Тус оролцооны хяналт шинжилгээ үнэлгээнд жендэрийн салбар хорооны болон хэрэгжүүлэгч багийн гишүүд, жендэрийн мэргэжилтэн, төрийн албан хаагчид, иргэдийн төлөөлөл зэрэг нийт 213 хүн оролцсон бөгөөд 2016-2019 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 18 арга хэмжээнээс 45.4% нь бүрэн хэрэгжиж, 36.4% нь хэрэгжих шатандаа, 18.2% нь хэрэгжээгүй ба нийт хэрэгжилтийн дунджийг 77.8%-ийн хэрэгжилттэй гэж дүгнэсэн байна.

Энэ нь хөтөлбөрийн төлөвлөсөн үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлтийг хангахад анхаардаггүй, байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоо хангалтгүй, санхүүжилт хүрэлцээгүй, удирдлагын болон мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар хангалтгүйгээс болжээ.

Мөн цаашид хөтөлбөрийн үйл ажиллагаа, суурь шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлж, иргэд, олон нийтийн жендерийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээрх мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг шинэлэг арга зүй, хэлбэрээр хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж тус оролцооны хяналт шинжилгээ үнэлгээгээр дүгнэсэн байна.

2.1.3. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2017-2020 онд орон нутгийн төсвөөс 2,599.1 сая, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 1,421.7 сая, улсын төсвийн

хөрөнгө оруулалтаар 22,634.4 сая, олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 556.5 сая нийт 27,211.7сая төгрөг зарцуулсан байна. */Дэлгэрэнгүй хавсралт-3/*

*Хүснэгт 6. Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв, гүйцэтгэл: сая.төг/*

| Он | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Орон нутаг /үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардал/ | | |
| 2017 он | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2018 он | 228.4 | 215.0 | 13.5 | 94.1 |
| 2019 он | 189.8 | 189.6 | 0.2 | 99.9 |
| 2020 он | 221.2 | 181.5 | 39.7 | 82.1 |
| Дүн | 639.4 | 586.1 | 53.3 | 91.7 |
| | | Орон нутаг Ангилагдаагүй зардал/ | | |
| 2017 он | 718.9 | 718.7 | 0.2 | 99.97 |
| 2018 он | 430.0 | 430.0 | 0.0 | 100.00 |
| 2019 он | 554.7 | 554.2 | 0.5 | 99.90 |
| 2020 он | 511.3 | 310.2 | 201.1 | 60.67 |
| Дүн | 2,214.9 | 2,013.0 | 201.8 | 90.9 |
| | | Орон нутгийн хөгжлийн сан | | |
| 2017 он | 49.4 | 49.4 | 0.0 | 100.00 |
| 2018 он | 375.4 | 375.4 | 0.0 | 100.00 |
| 2019 он | 229.1 | 229.1 | 0.0 | 100.00 |
| 2020 он | 767.8 | 767.8 | 0.0 | 100.00 |
| Дүн | 1,421.7 | 1,421.7 | 0.0 | 100.00 |
| Орон нутгийн дүн | 4,276.0 | 4,020.8 | 255.2 | 94.03 |
| | | Улсын төсөв | | |
| 2017 он | 2883.2 | 2883.2 | 0.0 | 100.00 |
| 2018 он | 4535.3 | 4535.3 | 0.0 | 100.00 |
| 2019 он | 8398.6 | 8398.6 | 0.0 | 100.00 |
| 2020 он | 6817.3 | 6817.3 | 0.0 | 100.00 |
| Дүн | 22,634.4 | 22,634.4 | 0.0 | 100.00 |
| | | Олон улсын хандив тусламж | | |
| 2017 он | 0.0 | 0.0 | 0.0 | 0.00 |
| 2018 он | 33.4 | 33.4 | 0.0 | 100.00 |
| 2019 он | 133.5 | 133.5 | 0.0 | 100.00 |
| 2020 он | 389.6 | 389.6 | 0.0 | 100.00 |
| Дүн | 556.5 | 556.5 | 0.0 | 100.00 |
| Нийт дүн | 27,466.9 | 27,211.7 | 255.2 | 99.07 |

*Эх сурвалж: 2017-2020 оны Баянхонгор аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл*

Дээрх төсөл хөтөлбөрүүдийг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 4,276.0 сая төгрөгийн санхүүжилт баталж, гүйцэтгэлээр 4,020.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

*Хүснэгт 7. Орон нутгийн төсвөөс дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баталсан төсөв, гүйцэтгэл: сая.төг/*

| Он | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| 2017 он | 768.3 | 768.1 | 0.2 | 99.97 |
| 2018 он | 1033.8 | 1020.3 | 13.5 | 98.70 |
| 2019 он | 973.6 | 972.9 | 0.7 | 99.92 |
| 2020 он | 1500.3 | 1259.6 | 240.8 | 83.95 |
| Дүн | 4276.0 | 4020.8 | 255.2 | 94.03 |

*Эх сурвалж: 2017-2020 оны Баянхонгор аймгийн Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл*

Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан 34 дэд хөтөлбөрүүдийн зарцуулалтыг шалгахад “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-

2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг", "Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх" дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй ба бусад дэд хөтөлбөрүүдийн хувьд дараах байдалтай байна. Үүнд:

1. "Цахим архив-Баянхонгор" аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан төрийн архивын баримтыг цахим санд шилжүүлэх үйл ажиллагааны хүрээнд төрийн архивын баримтыг цахимжуулах үйл ажиллагааны хүрээнд гэрээгээр ажилласан 12 ажилтны цалинд 45.0 сая төгрөг зарцуулж давхардсан тоогоор 17 хөмрөгийн 853 хадгаламжийн нэгж буюу 59869 хуудсанд 852128 өгөгдөл оруулж цахим хувь үүсгэн хайлтад холбох ажлыг хийсэн байна.

2. "Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах" дэд хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр 1,800.0 сая төгрөгийн өртөг бүхий төрийн архивын зориулалтын барилга, орон нутгийн төсвөөс 17.7 сая төгрөгийн үндсэн болон нэмэлт нөөц сервер, DVD хуулагч, хард, 1.9 сая төгрөгийн үнэ бүхий тог баригч зэрэг тоног төхөөрөмжүүдийг шийдвэрлүүлж төрийн архив, архивын сан, баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулсан байна.

3. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд "Хариуцлагатай хамтарсан баг" чуулганыг 2017 оноос эхлэн жил бүр зохион байгуулж 20 сумын 28 хамтарсан багийн 775 төрийн албан хаагч хамрагдаж хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, арга зүйн чадвартай болох, хүүхэд гэр бүлийн асуудал кейс баримтжуулалтыг журмын дагуу хийж гүйцэтгэх чадварт суралцсан.

Тус 3 удаагийн арга хэмжээний зардалд НҮБ-ын хүүхдийн сан 80.8 сая, ДЗОУБ Баянхонгор-2 орон нутгийн хөтөлбөрөөс 15.2 сая, аймгийн ХГБЗХГ-ын хүүхэд хамгааллын зардлаас 9.1 сая, нийт 105.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. "Жендерийн эрх тэгш байдлыг хангах" дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс 2018 онд 5.0 сая төгрөгийн төсөв баталснаас сургалт, сурталчилгааны зардалд 4.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

5. "Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн авто замын сангаас 2.8 сая төгрөг шийдвэрлүүлж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг орчмын бүсэд зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох зорилгоор хурд сааруулагч, анхааруулах тэмдэг зэргийг байрлуулсан байна.

6. "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Нэгдсэн эмнэлэгт КТГ-ын аппаратыг байршуулах өрөө тасалгааны засвар үйлчилгээ, компьютер томографын төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийг Улсын гуравдугаар төв эмнэлэгт сургах зардалд 5.5 сая, Бууцагаан, Галуут, Баян-Өндөр сумдын эрүүл мэндийн төвийн ариутгалын аппарат худалдан авахад нийт 2.3 сая, аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд

улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 0.9 сая төгрөгийн өртөг бүхий хөргөгчийн хэм, хяналтын хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч зэрэг бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг худалдан авч эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалт, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд Ковид-19 цар тахлын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, оношлуур зэрэгт аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу нийт 1,180.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, 279.1 сая төгрөгийн эмийн нөөц бүрдүүлж, НҮБ-ийн хүн амын сангийн төслөөр 10.2 сая төгрөгийн хамгаалах хэрэгсэл, ЭМЯ-ны санхүүжилтээр 1,073.0 сая, барилга байгууламж, автомашин парк шинэчлэлт, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм урвалж, оношлуур, хамгаалах хувцас хэрэгслийн зардалд орон нутгийн төсвөөс 5.0 сая , улсын төсвийн болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 17,000.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн.

7. “Хуримтлалтай Хонгорчууд” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төсвөөс сургалт, сурталчилгааны зардалд 2018 онд 7.5 сая, 2020 онд 5.4 сая төгрөгийг “Хонгорын зөн” ТББ-д олгож, Дэлхийн Зөн" ОУБ-аас Монгол улсад нэвтрүүлсэн “Дундын хадгаламжийн бүлэг” олон улсын аргачлалыг ашиглан иргэд, хамт олон нэгдэж шинээр бүлэг үүсгэн, тэдэнд сургалт хийж ажиллажээ. Үүний үр дүнд 2018 онд Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Баянхонгор суманд 15 бүлэг үүсгэж, 260 гаруй хүн, 2020 онд Баянхонгор суманд 20 бүлэг үүсгэж, 300 хүнийг хуримтлал хийх дадлага, туршлагатай болгож, түүнээсээ бизнес, эрүүл мэнд, боловсрол, өдөр тутмын ахуйн хэрэгцээнд зориулж нийт хуримтлалын 56%-ийг зээлд олгосон байна.

Олгосон зардлаас 2020 онд өмнөх онуудад үүсэн бий болсон Баянхонгор сумын 14, Өлзийт сумын 15, Эрдэнэцогт сумын 10, Галуут сумын 7, Дэлхийн Зөн-2 хөгжлийн хөтөлбөрийн 77 бүлгийг бэхжүүлэх, хяналт мониторинг хийхэд тодорхой хувийг зарцуулсан байна.

8. “Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлийн дагуу гарын авлага материал бэлтгэн түгээж эрүүл дадал хэвшлийг сурталчлах арга хэмжээнд 2018 онд орон нутгийн төсвөөс 6.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

9. “Эрүүл мэндийн ажилтны хөгжил” хөтөлбөрийн мэргэжил ур чадварыг дээшлүүлэн иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанарыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломж нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн дэмжлэгт оролцоо, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд орон нутгийн төсвөөс нийт 33.4 сая төгрөгийг зарцуулж эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагын тогтолцоог жигд төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалт сурталчилгааг сайжруулах, салбарын хэмжээнд эмч эмнэлгийн мэргэжилтэн, сувилагч, багийн эмч бусад тусгай мэргэжилтнүүдийг стандартын дагуу ханган ажиллуулж төгсөлтийн дараах болон ажлын байрны сургалтад хамруулсан байна.

10. “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийн аймгийн хүн амын дундах вирусийн халдварын тархалтыг хязгаарлан гепатитын В, С вирусийн халдварын шинэ тохиолдлыг бууруулах, вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах зорилтын хүрээнд орон нутгийн төсвөөс 2019-2020 онд нийт 40.0 сая төгрөгийг аймгийн Эрүүл мэндийн газарт шилжүүлэн зарцуулсан байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 онд хүн амыг хипатетийн В, С вирусын халдвар тодорхойлох шинжилгээнд хамруулах хувийг 80%-д хүргэхээр төлөвлөсөн боловч тус үзүүлэлт 2020 онд 5 хувь, 2021 онд 2 хувь гарч, зорилтот түвшиндээ хүрээгүй ба энэ нь дэлхий нийтэд гарсан ковид 19 цар тахлаар өвчилж халдвар авсан хүний тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.

11. “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” аймгийн дэд хөтөлбөр нь 2020 оны 08 дугаар сарын 26-нд баталсан бөгөөд 2021 онд аймгийн ГХУСАЗСЗ-ийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 3.0 сая төгрөг зарцуулсан ба 2017 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг 223 гарч болсон жил ирэх тусам гэмт хэргийн тоо буурсан үзүүлэлттэй, 2020 онд 111 гэмт хэрэг гарчээ.

12. “Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах” дэд хөтөлбөр, “Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028” дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг “Баянхонгор аймгийн орон нутгийн төсөвт байгаль орчноос орж ирж байгаа хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар авч үзсэн ба тус хөтөлбөрт улсын төсвөөс 345.6 сая, орон нутгийн төсвөөс 50.0 сая, нийт 395.6 сая төгрөг зарцуулсан байна. Хөтөлбөр хэрэгжсэнээр 2020 оныг 2018 онтой харьцуулахад амьсгалын замын цочмог халдварт өвчлөлийн түвшин 10000 хүн амд 382.08-аас 235.1, амьсгалын замын өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын тоо 1.97-оос 1.64 болсон байна.

13. “Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 10 багийн өрх толгойлсон 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 113 эцэг, эхийн судалгааг гаргуулан 42 өрхийг сонгон 2.2 сая төгрөгийн хүнсний материал болон дархлаа сайжруулах багцад хамруулсан мөн модон эдлэл, оёдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 иргэнийг 10.0 сая төгрөгийн төсөлд хамруулсан, 1 өрхийн газар тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлж, 4 иргэнийг ажилд зуучлах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн.

14. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” дэд хөтөлбөрийн хүрээнд барилга, уул уурхайн салбарт хөдөлмөрийн хяналтыг 42 аж ахуйн нэгж байгууллагад зохион байгуулан, хөдөлмөрийн аюулгүй байдлын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж албан шаардлагыг хүргүүлэн зөрчлийг нь арилгуулан ажилласан. Үзлэгийн үр дүнд үйлдвэрлэлийн осол өмнөх оны мөн үетэй харьцуулахад 86 хувиар буурсан байна. Уул уурхайн салбар дахь ХАБЭА-н стандарт мөрдөлт 90 хувьтай болсон үзүүлэлттэй гэж

тайлагнасан ч үйлдвэрлэлийн осол 2017 онд 1 гарсан бол 2018 онд 4, 2019 онд 10, 2020 онд 9 гарсан байна.

15. "Соёлын ажилтан" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ХДТ-ын уран бүтээлчид, соёлын ажилтнуудын мэргэжил ур чадварыг дээшлүүлэн хөгжүүлэх, уран бүтээлчид соёлын ажилтнуудыг чадавхжуулан ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор нийт 60 цагийн сургалт зохион байгуулсан нь соёлын ажилтан, багш нарын мэргэжил ур чадварт тодорхой ахиц гарсан. Мөн орон нутгийн төсвөөс аймгийн ХДТ-ын 8 уран бүтээлчийг мэргэжлийн сургуульд суралцахад 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

16. "Баянхонгор робокон" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд "Баянхонгор-Робокон 2020" аймгийн аварга шалгаруулах уралдааныг 2020 оны 10 дугаар сард зохион байгуулж Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соого сейко, Өлзийт, Жинст, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Бууцагаан, Галуут, Баян-Овоо, Эрдэнэцогт, Шаргалжуутын 80 сурагч оролцлоо. "Баянхонгор-Робокон" хөтөлбөр хэрэгжсэнээр дэлхий даяар хөгжиж байгаа "Хиймэл Оюун ухаан" буюу робот программчлалыг хийж бүтээж сурсан бөгөөд хүүхдийн бүтээх, сэтгэх чадвар илүү сайжирсан байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 5,0 сая төгрөг шийдвэрлүүлсэн байна.

17. "Үндэсний спортыг хэрэгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн үндэсний шагайн харвааны тэргүүн Б.Энхтүвшингийн санаачилгаар шагайн харвааны төв байрыг 6.0 сая төгрөгөөр засварлаж шагайн спортоор хичээллэгсдийн орчныг сайжруулсан, мөн аймгийн үндэсний сурын холбоотой хамтран Ерөнхий боловсролын сургуулиудад нийт 75.0 сая төгрөгийн үнэ бүхий үндэсний сурын иж бүрэн хэрэглэл, сургалтын материалаар хангаж, сургууль тус бүрийн нэг багшийг үндэсний сурын багшаар мэргэшүүлэн бэлтгэсэн байна.

18. "Сайн багш" дэд хөтөлбөрийн хүрээнд боловсролын үйлчилгээний хүртээмж чанар, үр ашгийг дээшлүүлэх зорилгоор салбарын хүний нөөцийг боловсронгуй болгож багш нараас мэргэжлийн шалгалт авах ажлыг зохион байгуулсан, сургалтын менежерүүдэд сургууль дээрээ багшийн мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллах чиглэл өгч "хэрэглэдэг хөтөлбөр" сургалтын хөтөлбөр боловсруулах уралдаан зарлаж 6 сургалтын менежерийг шалгаруулсан байна.

Мөн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын мэргэжлийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор "Дидактикийн үндэс" сургалтыг 25 сургууль, 37 цэцэрлэг дээр зохион байгуулж 950 гаруй багш, удирдах ажилтан хамрагдаж сургалтын дидактик арга зүйгээр мэдлэг боловсролоо дээшлүүлсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтын аймгийн дундаж үзүүлэлт улсын дунджаас доогуур байгаа ч сүүлийн жилүүдэд аймгийн дундаж үзүүлэлт өссөн байна.

| Он | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|
| Улсын дундаж оноо | 502.1 | 509.0 | 513.0 | 523.0 |
| Аймгийн дундаж оноо | 479.2 | 489.5 | 508.4 | 512.4 |

19. “Хос бичигтэн” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас 5,0 сая төгрөг зарцуулж 17 сумын 2677 төрийн албан хаагч буюу улс төрийн 96, төрийн захиргааны 340, төрийн үйлчилгээний 2163, төрийн тусгай 78 албан хаагчдаас үндэсний бичгийн мэдлэг, чадварыг тогтоох судалгаа авч мөн аймгийн хэмжээний 26 сургуулийн 8 дугаар ангийн 57 бүлгийн 1400 гаруй сурагчийг оролцуулсан “Хос бичигтэн хамт олон “ уралдаант ажлыг дүгнэж урамшуулсан байна.

20. “Амар тайван амьдрал” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр 2020 онд 7.8 сая төгрөгийг зарцуулсан. Мөн сургалт нөлөөлөл, мэдээ мэдээллийн олон тал арга хэмжээг зохион байгуулж, ажилласны үр дүнд тус онд нийт 462 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 156 нэгжээр буюу 25.2 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 54.5 хувиар буюу 4.6 пунктээр өссөн. Үүний дотор согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 122 болж 0.8 хувиар буурч, мал хулгайлах гэмт хэрэг, 67 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх мөн үеэс 22 нэгжээр тус тус буурсан үзүүлэлтэй байна. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны зардлаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 2017 онд 32259 байсан бол 2020 онд 23064 болж, 9185-аар буурсан байна.

21. “Залуучуудын хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн өсвөр үе, залуучуудын хөгжил оролцоог дэмжсэн 9 төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулан нийт 3160 өсвөр үе, залуучуудад хүрч ажилласан. Залуучуудын мэдээллийн санг 16 төрлөөр бүрдүүлж шийдвэр гаргагчид, салбар дундын хамтын ажиллагааг хэрэгжүүлэгч багуудад хүргэж, аймгийн 5 жилийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах зорилтыг тусгуулж ажиллаж байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр залуучуудын сонирхлын клуб 2018-2020 оны туршид 5-аас 15 болж нэмэгдэж, түүнд хамрагчдын тоо 60-160 болсон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг таниулах сургалт сурталчилгаанд хамрагдсан залуучуудын тоо 6000-15000 болж өссөн, насан туршийн боловсролын төвд зуучлан бичиг үсэгтэй болсон хүний тоо 20%-56%-д хүрчээ.

22.“Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд шинэ болон сэргэж байгаа халдварын тархалтыг бууруулах чиглэлээр томуу, томуу төст өвчний дэгдэлтийг бууруулах, шинэ коронавирусын халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэн, “Шинэ коронавирусын халдвараас

сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, нөөц бүрдүүлэхэд шаардлагатай хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис, тоног төхөөрөмж худалдан авахад нийт 140.3 сая төгрөгийг зарцуулсан ба 2018 онд халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо 1460 байсан бол 2020 онд 1328 болж буурсан байна.

"Хонгорчууд халдварт өвчний эсрэг хамтдаа" аяны хүрээнд Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарийн баг Шинэжинст, Богд сумдад ажиллаж, үзлэгт хамрагдах ёстой зорилтот насны иргэдийг 87-98 хувьтай хамруулж, аймгийн хэмжээнд эхний 11 сарын байдлаар нийт 17535 иргэдийг ХДХВ/ДОХ, тэмбүүгийн шинжилгээнд хамруулж, сорил баталгаажиж, өвчлөлтэй гарсан 630 тохиолдлыг эмчлэн эрүүлжүүлсэн байна.

2020 оны эхний 11 сарын байдлаар нийт халдварт өвчин 1231 бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.1 дахин буурсан. Нийт халдварт өвчин дотор бэлгийн замаар дамжих халдварын эзлэх хувь 79.4. Тэмбүү, заг хүйтний өвчлөл ноднин жилээс буурсан, трихомониаз ноднингийн үеийн түвшинд байна. Сүрьеэгийн өвчлөл өмнөх оноос 13 тохиолдлоор буурсан байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 2020 оны 2017 онтой харьцуулахад уушгины нян судлалын шинжилгээгээр батлагдсан сүрьеэгийн шинэ тохиолдлын эмчилгээний үр дүн 80 хувиас 95 хувь болж, бэлгийн замын халдварт өвчнүүдийн тоо буурсан үзүүлэлттэй байна.

23. "Тунгалаг санхүү" хөтөлбөрт 2019-2020 онд ангилагдаагүй зардлаас 19.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 18.6 сая төгрөгийн зарцуулсан ба хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн ажилтнуудад сургалт, үзүүлэх сургалт, аймгийн засаг даргын нэрэмжит хяналт шалгалт, мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулснаар анхан шатны болон нягтлан бодох бүртгэл сайжирсан, орон нутгийн төсвийн байгууллагууд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болсон, нийт нягтлан бодогч нийтлэг алдаа дутагдлыг бууруулж, бүртгэлийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулан, байгууллагын удирдлага, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт, мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулснаар жишиг санхүүгийн алба бий болгосон байна.

"Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах, нэгдсэн төлөвлөгөө"-г батлан, байнгын хяналт тавьж ажилласнаар Монгол Улсын Сангийн яамнаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн 2017 оны 87.0 хувийн үнэлгээг 2018 онд 94.0, 2019 онд 99.3 хувь болж нэмэгдүүлсэн ч мэдээллийн чанар, ач холбогдол, үнэн зөв байдлыг шалгахад хугацаанд нь үнэн зөв байршуулах явдал бүрэн сайжирч чадахгүй байна.

24. "Ахмадаа ачилья" дэд хөтөлбөрт орон нутгаас 2018 онд 10.0 сая төгрөгийг хуваарилснаас аймгийн Засаг даргын 2018 оны А/419 дүгээр захирамжаар "Ахмадын зөвлөх үйлчилгээ, хөгжил оролцооны төв" байгуулахад 7.9 сая, А/355 дугаар захирамжаар ахмадын софт волейбол, граунт голвф, дардасын спортыг

хөгжүүлэх хэрэгсэл авахад 2.1 сая төгрөгийг зарцуулж, 2019 онд 3.0 сая төгрөг батални аймгийн Ахмадын хороонд шилжүүлснийг ахмадын оюун ухааны анхдугаар олимпиад зохион байгуулахад 2.0 сая, эмзэг бүлгийн ахмадуудад дэмжлэг үзүүлэхэд 1.0 сая төгрөгийг зарцуулжээ.

25. "Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас шийдвэрлэсэн санхүүжилтийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн санд хуваарилж, улсын төсвөөс хуваарилсан "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" хөтөлбөрийн санхүүжилтийн хамт шалгуур үзүүлэлтийн дагуу малчдад эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгох, сургалтад хамруулах ажлыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулсан байна.

"Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийн мал аж ахуйн чиглэлийг дэмжиж 2017-2020 онд орон нутгийн төсвөөс нийт 390.0 сая төгрөгийг олгосныг 400 өрхийг малжуулахад зарцуулсан байна. Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн "Илгээлтийн эзэн аймгийн дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 15 дугаар тогтоолоор "Илгээлтийн эзэн" аймгийн дэд хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 2.3 дах заалтад "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг аймаг, сумын комисс боловсруулан, үр дүнг жил бүр тооцож амжилттай хэрэгжүүлсэн өрхүүдэд олгосон дэмжлэгт орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн төлбөрөөс чөлөөлнө" гэж нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүний дагуу тус хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлсэн 2017-2019 онд 295 өрхөд олгосон 287.6 сая, 2020 онд олгосон 100 өрхийн 100.0 сая төгрөгийг чөлөөлсөн байна.

"Илгээлтийн эзэн" дэд хөтөлбөрийн газар тариалангийн чиглэлээр 2017-2019 онд нийт 146.0 сая төгрөг олгож, Баянхонгор аймгийн Засаг даргын санаачилгаар "Өвгөдийн шанд" ХХК-ийн захирал Б.Отгонбилэгээр ахлуулан "Жишиг өрх" төслийг хэрэгжүүлж, орон нутгийн ажилгүй, орлого багатай өрхүүдийг хамруулж, газар тариалан эрхлэх бүрэн боломжоор хангаснаар орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэн өгч, өрхийн хэрэгцээний 0.07 га газар, эрчим хүч, үр, бордоо, суулгацуудаар хангаан хашаажуулан төмс, хүнсний ногоо, хамгаалагдсан хөрс буюу хүлэмж, гүн өрмийн худаг гаргах зэрэг ажлуудыг хийж, 90 зорилтот өрхийг хамруулсан байна. Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/250 дугаар "Жижиг өрхийн тариалалт" төслийн үйл ажиллагааг дүгнэх ажлын хэсгийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар ахлуулан, салбар бүрээс төлөөлөл оруулсан 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсэг 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдөр 90 зорилтот өрхийн тариалалт хийсэн байдал, арчлалт, хамгаалалтыг шалгаж, ажлын хэсэг тус арга хэмжээг үр дүнтэй хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

26. "Торгон сүрэг" хөтөлбөрийн хүрээнд 2017 онд бог малын хээлтүүлэгчийн сан бүрдүүлэх арга хэмжээнд аймгийн ОНХС-аас 49.4 сая, 2018 онд 50.0 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 2017 онд Баянбулаг, Бөмбөгөр, Шинэжинст сумдад 230 хурган хуц, 500 ухна ишиг, 2018 онд Хүрээмарал, Шинэжинст,

Бөмбөгөр сумдад 200 хурган хуц, 400 ухна ишиг худалдан авч хээлтүүлэгчийн санг бүрдүүлсэн байна. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар "Бог малын хээлтүүлэгч бойжуулж бэлтгэх, үржилд ашиглуулах" журам баталж, Залаажинст эдрэнгийн үүлдрийн 85, Бөмбөгөрийн улаан омгийн 33, Байдраг үүлдрийн 15, Баянбулаг сумын нутгийн хонь 171, Өлзийт сумын нутгийн хонь 8 хээлтүүлэгчийг сумдад хуваарилсан ба хээлтүүлэгчийн санд 2017 онд бэлтгэсэн хуц 209, ухна 115, 2018 онд бэлтгэсэн 196 хуц 226 ухна бүртгэлтэй байна.

Хээлтүүлэгчийн санд бүртгэлтэй хуц, ухны ашиг шимийн орлого, бүртгэл тайлагналыг цаашид аудитаар тодруулж үзэх нь зүйтэй байна.

27. "Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг 2019-2020 онд хэрэгжихээр баталж, хөтөлбөрийн хүрээнд хуучин байрнуудын дулаан алдагдлыг бууруулж иргэдийг ая тухтай амьдрах орчин бүрдүүлэх ажлын хүрээнд 2019 онд Баянхонгор суманд 12, 30, 34 дүгээр байр, 2020 онд 14 дүгээр байрны дээвэр, гадна пасад, орцны засварын ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна.

28. "Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого" дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд байнгын шинэ ажлын байрны тоог нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэр, загвар хоршоодыг санхүү зээлийн бодлогоор дэмжих зорилгоор орон нутгаас санхүүжилт хуваарилж, зээлийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулж, "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК-аар дамжуулан жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг олгож, хүнсний үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэж ажилласан байна.

Орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийг нийт 172 зээлдэгчид олгож, байнгын 177, түр 191, улирлын чанартай 178, нийт 546 ажлын байр бий болсон ба үйл ажиллагаа, салбарын чиглэлээр авч үзвэл 35.4 хувийг хөнгөн үйлдвэрлэлд, 29.2 хувийг бусад салбарт, 20.9 хувийг хүнсний үйлдвэрлэлд, 11.6 хувийг газар тариаланд, 2.9 хувийг мал аж ахуйн салбарт олгосон байна.

Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлогын хүрээнд байгуулах үйлдвэрийн жагсаалтыг баталснаас дараах үйлдвэрүүд бий болжээ. Үүнд:

- Эрдэнэцогт суманд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрийг "Витафит" ХХК 10.0 тэрбум төгрөгөөр барьж ашиглалтад оруулж, 2022 оноос нутгийн 60 гаруй өрхөөс 100 тонн түүхий эд авч, өдөрт 1.5 тонн бүтээгдэхүүн боловсруулж 2 сар ажилласан байна.
- Хөдөө аж ахуйн кластер төслийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ингэний сүүний үйлдвэр байгуулах ажлыг 2021 оноос эхлүүлэн барилгыг барьж ашиглалтад бүрэн хүлээн аваагүй байна.
- Баян-Өндөр суманд "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах" төслөөс 80.0 сая, сумын ОНХС-аас 75.0 сая, нийт 155.0 сая төгрөгийн

санхүүжилтээр пробиотик сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэр ашиглалтад орсон, үйлдвэрт ажиллах боловсон хүч, түүхий эдийн хомсдолоос шалтгаалж одоогоор ажиллаагүй байгаа нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан.

29. "Хоршоог хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд Бөмбөгөр сумын "Унаган хүр" хоршоонд ЖДҮХС-аас 5 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй 40.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгожээ. "Тогтвортой ноолуур" төслөөс Баян-Өндөр сумын "Цагаан ямаат", Баянцагаан сумын "Баян гичгэнэ" хоршоонд нийт 230.0 сая төгрөгийн агуулах, автомашины хөрөнгө оруулалт хийсэн, НҮБ-ийн "Юнидо" төслөөс 10 сумын 10 аж ахуйн нэгжид мал төхөөрөх тоног төхөөрөмжийг олгожээ.

30. "Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрт орон нутгийн төсвөөс 2018 онд 10.0 сая төгрөг баталсныг аймгийн Засаг даргын А/519 дүгээр захирамжаар "Эмэгтэйчүүдийн манлайлал" сургагч багш бэлтгэх сургалт, "Ирээдүйн аав, ээж", "Залуу гэр бүл хайрын холбоо", "Эрүүл аз жаргалтай гэр бүл", "Хөршийн холбоо", "Сайн эхнэр" зэрэг арга хэмжээ зохион байгуулахад зарцуулсан байна. Дэд хөтөлбөрийн хүрээнд 2020 онд 7.0 сая төгрөгийг баталж, "Мед буян трейд" ХХК-аас тэргэнцэртэй эмэгтэйчүүдийн үзлэгийн ор 6.9 сая төгрөгөөр худалдан авч, аймгийн Нэгдсэн эмнэлэгт өгсөн байна.

31. "Ухаалаг Баянхонгор" дэд хөтөлбөрийн хүрээнд "Нийтийн үүргийн сан"-аас санхүүжүүлэн Баянлиг, Баянговь сумдыг шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбосон, Баянхонгор сумын 2,3,7,9 дүгээр багийн нутаг дэвсгэрийн 80 хувийг хамарсан аваарын сирень дохио, ерөнхий гэрэлтүүлэг, хяналтын камер суурилуулах, утасгүй сүлжээний орчин бүрдүүлэх ажилд аймгийн ОНХС-аас 300.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр 274.0 сая төгрөгөөр "Баттод" ХХК гүйцэтгэсэн ба ажил бүрэн хийгдэж дуусаагүй байна. Аймаг, сумын ОНХС-аас "Цахим мэдээллийн нэгдсэн систем" хөгжүүлэх арга хэмжээнд 76.0 сая төгрөгийг баталж, "Тауэрсофт" ХХК 74.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Мөн тус хөтөлбөрийн хүрээнд Баянхонгор сумын хэмжээнд бүх цахилгаан эрчим хүч хэрэглэгч нарын тоолуурыг ухаалаг тоолуурт шилжүүлэх, сумдын ундны усны худгийг бүрэн ухаалаг системд шилжүүлэх, аймгийн хэмжээний цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлтийг хийж аймгийн хэмжээний мэдээллийг 1 платформоос авах боломжийг бүрдүүлсэн, төрийн байгууллагын дотоод удирдлага хяналтын нэгдсэн ERP системд нэвтрүүлэх зэрэг гол ажил арга хэмжээнүүдийг тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлсэн зэрэг арга хэмжээг зохион байгуулсан байна.

32. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" дэд хөтөлбөрийн хүрээнд орон нутгаас төсөв баталдаггүй, 2020 онд 10.0 сая төгрөгийн санхүүжилт баталсан боловч олгоогүй байна. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас улсын төсвөөс ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулахаар 2017-2020 онд нийт 5,936.4 сая төгрөгийг зарцуулж, 18270 ажлын байрыг нэмэгдүүлсэн ба хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2017 онд 61.5

хувьтай байсан бол 2020 онд 62.8 хувь болсон ч төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг 70 хувьд хүргэхээс 65.3 хувь болж төлөвлөсөндөө хүрээгүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарсан ололттой дэд хөтөлбөр

**Сайн жишээ:**

*"Цахим архив"дэд хөтөлбөр нь Монгол улсын хэмжээнд төрийн болон байгууллагын архивын баримтыг мэдээллийн технологид шилжүүлэх үйл ажиллагаанд анх удаа жишиг тогтолцоог бүрдүүлж ирснээр архивын баритыг цахимжуулах арга зам, үндэсний тогтолцоог бий болгоход түүхэн үүрэг гүйцэтгэсэн байна. Хөтөлбөр хэрэгжсэнээр Төрийн архивын санд байгаа 1997-200 оны зорилтот 92228 баримт, байгууллагын архиваас 2001-2017 оны шинээр Төрийн архивд шилжин ирсэн 91000 баримт цахим санд шилжсэнээр лавлагаа мэдээллийн үйл ажиллагааны хайлт автоматжиж, үйлчилгээний хүртээмж чанарт ахиц дэвшил гарч, хадгалат хамгаалалт сайжирч, баримтууд ашиглалтаас чөлөөлөгдсөн зэрэг үйл ажиллаганы үндсэн үзүүлэлтээр улсад тэргүүлж байна.*

2.1.4. Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан дээрх төсөл хөтөлбөрүүдийг аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 4,020.8 сая төгрөгийг зарцуулснаас 1,050.8 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, 2,970.0 сая төгрөгийг арга хэмжээний урсгал зардалд зарцуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалт олон улсын хандив тусламжаар 23,190.9 сая төгрөгийн зарцуулснаас нийт 1,735.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна. */Хавсралт №4/*

**2.2.Баталсан төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийг журамд заасан хугацаанд аймгийн ИТХ-д иж бүрэн тайлагнаагүй байна.**

2.2.1.Аймгийн ИТХ-аас баталсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр журамд заасан хугацаанд тайлагнаагүй байна. Тухайлбал:

Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2017 оны хэрэгжилтийг тайлагнаагүй, 2018 оны хэрэгжилтийг 2019 оны 03 дугаар сарын 19-нд аймгийн ИТХ-д хүргүүлсэн байгаа нь Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 8.1[7] дэх заалтыг зөрчсөн байна.

*Хүснэгт 8. Аймгийн ИТХ-д хэрэгжилтийг тайлагнасан дэд хөтөлбөрүүдийн нэгтгэл*

| 2018 он | | 2019 он | | 2020 он | |
|---|---|---|---|---|---|
| Биелэлтийг хүргүүлсэн | | Биелэлтийг хүргүүлсэн | | Биелэлтийг хүргүүлсэн | |
| Хөтөлбөрийн тоо | огноо | Хөтөлбөрийн тоо | огноо | Хөтөлбөрийн тоо | огноо |
| 24 | 2019.03.19 | 26 | 2019.12.17 | 32 | 2021.01.10 |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-аас ирүүлсэн хэрэгжилтийн тайлан*

Цаашид бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

[7] *Захиргааны байгууллага нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авч, хэрэгжилтийг салбар, чиглэлээр ангилан энэхүү журмын 6 дугаар хавсралтын дагуу гаргаж тайланг журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд харьялах дээд шатны байгууллагад хүргүүлнэ.*

нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.2.2.Аймгийн Засаг дарга нь аймгийн ИТХ-ын төсөл, хөтөлбөр баталсан тогтоолуудын хэрэгжилтийг жил бүр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулах үүрэгтэй бөгөөд аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтсээс уг тогтоолын хэрэгжилтийг 2019 онд тайлагнаж ажилласан ч хэрэгжилтийг бүрэн тооцоогүй, төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг бүрэн тайлагнаагүй байна.

Тухайлбал "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр", "Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого", "Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг", "Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх" дэд хөтөлбөрүүдийн 2019 оны хэрэгжилтийг аймгийн ИТХ-д тайлагнаагүй байна.

*Хүснэгт 9. Аймгийн ИТХ-д хэрэгжилтийг тайлагнасан дэд хөтөлбөрүүдийн нэгтгэл /тоо, хувиар/*

| Он | Тайлагнавал зохих төсөл, хөтөлбөрийн тоо | Тайлагнасан төсөл хөтөлбөрийн тоо | Хэрэгжилтийн дундаж хувь |
|---|---|---|---|
| 2018 | 24 | 24 | 75.0% |
| 2019 | 31 | 27 | тооцоогүй |
| 2020 | 32 | 32 | 84.1% |

*Эх сурвалж: Эх сурвалж: Аймгийн ИТХ-аас ирүүлсэн хэрэгжилтийн тайлан*

## БҮЛЭГ 3. Аймгийн ИТХ-аас 2017-2020 онд баталсан дэд хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэрэгжсэн нийт хугацааны байдлаар тооцож ажиллаагүй байна.

### 3.1. Аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.8[8], Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 1 дүгээр хавсралтад "Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон дэд хөтөлбөрийн тайланг жил бүрийн 02 дугаар сарын 20-ны дотор ИТХ-д танилцуулна, явцыг жил тутам, хяналт-шинжилгээ үнэлгээг 2 жил тутам, шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийнэ" гэж заасны дагуу дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг аймгийн ИТХ зохион байгуулахаар байхад 2017-2021 онд баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгээгүй байна.

Харин аймгийн Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн А/765 тоот захирамжаар аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хэрэгжүүлэх

*[8] Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.*

үндсэн чиглэл, дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэдээс хэрэглэгчийн үнэлгээ авч, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг аймгийн Ахмадын хорооны дэргэдэх "Ахмадын зөвлөгөө өгөх төв"-өөр хийлгэхээр гэрээ байгуулан ажилласан байна.

Тус төвийн 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдөр бичсэн Хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай танилцуулга"-д / дэд хөтөлбөрийн талаар дараах байдлаар дүгнэсэн байна. Үүнд:

- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт 2016-2020 онд нийт 34 төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөсний 25 нь 2017 онд батлагдахаар үндсэн чиглэлд тусгагдсан байхад ганцхан "Амар тайван амьдрал" хөтөлбөр л хугацаандаа батлагджээ;
- "Элэг бүтэн Баянхонгор", "Агаарын хөрс усны бохирдлыг бууруулах", "Ахмадаа ачилья", "Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих" зэрэг 6 хөтөлбөр 11 дүгээр сарын 29-нд буюу захирамжид заасан хугацаанаас 9 сараар хожимдож гарчээ;
- Зарим хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарах шалгуур үзүүлэлтэд нөгөө тулгамдаж байгаа асуудлаа хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгаагүй;
- Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүжилтийн тооцоо судалгаа нь аймгийн төрийн сангийн бодлого төлөвлөлттэй төдийлөн уялдаж чадаагүй байна гэжээ.

3.1.2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийснийг шалгахад Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3[9] дэх заалтын дагуу аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн тайланд тусгасан ангилагдаагүй зардлаас олгосон 8 дэд хөтөлбөрийн 31.2 сая төгрөгийн зардалд хяналт шалгалт хийсэн ба аудитаар алдаа илрээгүй байна.

*Хүснэгт 10.Баянхонгор аймгийн СХАА-аас хийсэн хяналт шалгалт (сая.төг)*

| № | Дэд хөтөлбөрийн нэр | Хөтөлбөрт тусгасан зардал |
|---|---|---|
| 1 | Хуримтлалтай хонгорчууд | 5.4 |
| 2 | Соёлын ажилтан | 3.0 |
| 3 | Баянхонгор робокон | 2.1 |
| 4 | Сайн багш | 6.8 |
| 5 | Хос бичигтэн | 4.2 |
| 6 | Залуучуудын хөгжлийг дэмжих | 4.8 |
| 7 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | 2.0 |
| 8 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | 3.0 |
| | Дүн | 31.3 |

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн СХАА-ны 2022.06.28-ны өдрийн 156 дугаар албан бичиг*

## 3.2. Зарим дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, үр дүнг тооцсон байгаа болович журмын дагуу дууссан хөтөлбөрийн эцсийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийгээгүй байна.

3.2.1.Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдэд 2017, 2018 онд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, 2019-2021 оны үнэлгээ дараах байдалтай байна.

[9] *Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна.*

*Хүснэгт 11 .Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ*

| Он | Үнэлгээ хийсэн дэд хөтөлбөрийн тоо | Дундаж үнэлгээ |
|---|---|---|
| 2019 | 17 | 84.1 |
| 2020 | 29 | 85.6 |
| 2021 | 12 | 80.1 |

*Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн тайлан*

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлсэн байна.

*Хүснэгт 12 .Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ*

| дд | Дэд хөтөлбөрийн нэр | 2019 оны ХШҮХ-ээс үнэлсэн үнэлгээ | 2019 оны тогтоолын хэрэгжилтэд хийсэн үнэлгээ | 2020 оны үнэлгээ | Unelgee.mn системд 2021.02.21-ний өдөр оруулсан 2020 оны үнэлгээ | 2021 оны үнэлгээ /2021.07.07/ | 2021 оны үнэлгээ /2022.02.28/ | Unelgee.mn системд 2022.03.01-ний өдөр оруулсан 2021 оны үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Амар тайван амьдрал | 92.5 | 70 | 87.5 | 100 | | | |
| 2 | Хуримтлалтай хонгорчууд | | | 100 | 100 | урьд оны тайлангийн мэдээлэл давтагдсан | 35 | 35 |
| 3 | Тунгалаг санхүү | | 70 | 100 | 100 | 74 | | |
| 4 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | 100 | 100 | | | |
| 5 | Ахмадаа ачилья | 92.5 | 70 | 92.5 | 100 | урьд оны тайлангийн мэдээлэл давтагдсан | 92.5 | 92.5 |
| 6 | Ухаалаг Баянхонгор | | 30 | | 0 | | 51.32 | 51.32 |
| 7 | Соёлын ажилтан | 92.5 | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | 77.5 | 56 | | | |
| 8 | Баянхонгор робокон | 80 | 70 | 100 | 100 | | | |
| 9 | Сайн багш | 70 | 70 | 88 | 100 | | | |
| 10 | Хос бичигтэн | 80 | 70 | 80 | 100 | | | |
| 11 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | 80 | 30 | | | | | |
| 12 | Торгон сүрэг | 76.6 | | 92.5 | 92.5 | урьд оны тайлангийн мэдээлэл давтагдсан | 100 | 100 |
| 13 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | | | 77.5 | 70 | 52 | 90 | 90 |
| 14 | Баянхонгор аймгийг үйлдвэржүүлэх нэгдсэн бодлого | | 30 | | | | | 0 |
| 15 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | 100 | 100 | урьд оны тайлангийн мэдээлэл давтагдсан | | |
| 16 | Залуучуудын хөгжлийг дэмжих | | 30 | 70 | 100 | | | |
| 17 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 90 | 30 | 92.5 | 100 | урьд оны тайлангийн мэдээлэл давтагдсан | | |
| 18 | Илгээлтийн эзэн | 94 | 70 | 100 | 100 | | | |
| 19 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | | | 88 | 100 | 49 | 92 | 92 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | 70 | 70 | 90 | 100 | | | |
| 21 | Элэг бүтэн-Баянхонгор | 73.8 | 70 | 77.5 | 70 | | | |
| 22 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | 90 | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | 94.1 | 100 | 67.3 | 91.52 | 91.52 |
| 23 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | 90 | 30 | 96.6 | 92.6 | | | |
| 24 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | | 0 | 35 | 92.07 | 92.07 |
| 25 | Цахим архив Баянхонгор | 90 | 70 | 70 | 0 | 40 | 100 | 100 |
| 26 | Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих | 80 | тогтоолын хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй гэж үзсэн | 70 | 100 | 36 | 56.67 | 56.67 |
| 27 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | 87.5 | 70 | 92.5 | 100 | | | |
| 28 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | | 30 | 100 | 100 | | | |
| 29 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | | 70 | 94 | 100 | | | |
| 30 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | | 70 | 70 | 100 | 70 | 83.33 | 83.33 |
| 31 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | | | | | | | |
| 32 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | | | | | | | |
| 33 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | | | | | 46 | | 0 |
| 34 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | | 70 | 70 | 100 | 56 | 76.67 | 76.67 |
| | ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДЭД ХӨТӨЛБӨРИЙН ТОО | 17 | 27 | 27 | 29 | 15 | 12 | 14 |
| | ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ | 84.1 | 56.7 | 87.8 | 85.6 | 52.5 | 80.1 | 68.6 |

*Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын шийдвэрээр баталсан дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилт /Ботийн дугаар 2/3-9/, Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн "Дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ", "Аймгийн дэд хөтөлбөрүүдийн 2021 оны хэрэгжилтийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай" илтгэх хуудас*

Дээрх хүснэгтээс харахад аймгийн ИТХ-ын шийдвэрээр баталсан дэд хөтөлбөрөөс 2019 онд 17, 2020 онд 17, 2021 онд 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлээгүй байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2021 онд хийсэн үнэлгээний тайлангаас харахад "5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд өмнөх оны тайлангийн мэдээллийг бичсэн, мэргэжилтнүүдийн бичсэн жил бүрийн тайланд Засгийн газрын 2017 оны 89, 2020 оны 206 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаанд 2000 тэмдэгтэд багтаан үр дүнг чухалчилсан тайланг ирүүлэх" гэж дурджээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс аймгийн ЗДТГ-ын дарга Д.Энхжаргалд 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн 10 дугаар албан бичгээр 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Аймгийн Засаг даргад даалган гаргасан аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад чиглэсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний 2019 оны тайланд үндэслэн аймгийн Засаг даргад аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 8/24 дугаар албан бичгээр 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлжээ.

Тус хэлтсээс хүргүүлж байгаа хяналт шинжилгээ үнэлгээний тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хэдий хугацаанд ямар албан тушаалтан гүйцэтгэсэн нь тодорхой бус, цаашид авах арга хэмжээ болон ямар хугацаанд зөвлөмжийн биелэлтийг тайлагнах талаар бичээгүй, албан тушаалтнуудаас зөвлөмжийн биелэлтийг авч, хэрэгжилтийг тооцож ажиллаагүй байна. Иймд цаашид тайлан, зөвлөмжийн бүтэц, биелэлтийг тооцож ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлэв.

Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 8/1850 дугаар албан бичгээр "Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын 2013 оны 322, 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу дэд хөтөлбөрийн тайланг авдаггүй болно" гэж ирүүлсэн боловч new.unelgee.gov.mn сайтад 29 дэд хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг 1 хоногоор хоцроож, 18 дэд хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилтийг хугацаанд нь багтаан мэдээлсэн байна. Иймд цаашид төрийн аудитын байгууллагад ажил хариуцсан албан тушаалтнууд мэдээллийг үнэн зөв гаргаж ирүүлэх нь зүйтэй байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.7[10]-т заасныг хэрэгжүүлж, 2020 онд хугацаа дууссан дэд хөтөлбөрүүдийн эцсийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгээгүй байна.

Иймд цаашид 2020 оны 12 дугаар сард Засгийн газрын 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.8[11] дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

3.2.2. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4[12], 15.8[13]-т заасны дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын

---

[10] *Захиргааны байгууллага нь урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийн хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж дүнг журмын 9 дүгээр хавсралтын дагуу гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.*

[11] *Захиргааны байгууллага нь урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийг хүчингүй болсонд тооцсон, эсхүл хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хийж, дүнг энэ журмын 8 дугаар хавсралтын дагуу гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ; (Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан бөгөөд үүнийг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө)*

[12] *Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ.*

[13] *15.8.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хоёр жил тутам, дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал зохион байгуулна.*

24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний 5-т "Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тухай" асуудлыг батлансы дагуу аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс аймгийн ИТХ-аар 2017 онд баталсан 17 дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, танилцуулсан ба бусад онуудад дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хийсэн үнэлгээгээр 17 дэд хөтөлбөрөөс 8 дэд хөтөлбөр нь 90-100 хувийн хооронд үнэлэгдэж "Үр дүнтэй", 9 хөтөлбөр нь 89-70 хувийн хооронд үнэлэгдэж "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар аймгийн ИТХ-аар баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх үеийн баримт материал, тайлангийн мөрөөр цаашид ямар арга хэмжээ авах талаарх баримт материалыг аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй болно.

ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс аймгийн ИТХ-аас аймгийн Засаг даргад даалган гаргасан тогтоолын хэрэгжилтийг 2019 оноос хойших хугацааны шалгасан баримт материалыг ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2019 онд шалгасан ба нийт 37 тогтоолоос 21 тогтоол нь аймгийн дэд хөтөлбөртэй холбоотой гаргасан тогтоол байна.

Дээрх 21 дэд хөтөлбөрөөс 14 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 70 хувь буюу "Хэрэгжих шатандаа", 7 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг 30 хувь буюу "Хангалтгүй" гэж үнэлэн,"Соёлын ажилтан", "Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих", "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого", "Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил, хамгааллыг сайжруулах", "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, халдварт өвчнөөс сэргийлэх, хянах" зэрэг 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилт ирээгүй тул хяналтад аваагүй байна.

Иймд дэд хөтөлбөрийг хэрэгжиж дууссаны дараа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.16[14], 5.2.16[15], 6 дугаар зүйлийн 6.8[16] гэснийг хэрэгжүүлж, дэд хөтөлбөр хэрэгжсэн нийт хугацаагаар нэгтгэн дүгнэж, тайлагнаж ажиллах нь зүйтэй байна.

---

*[14] нэгтгэн тайлагнах зарчим;*

*[15] ."нэгтгэн тайлагнах зарчим" гэж энэ хуулийн 6.9-д заасан Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын Их Хуралд, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлад тайлагнахдаа энэ хуулийн 6.7, 6.8-д заасан баримт бичигт заасан зорилго, зорилт, хүрэх үр дүнтэй уялдуулан, тухайн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хүрэх үр дүнгийнхээ хэдэн хувьд хүрсэн, хөрөнгийн эх үүсвэр, хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу хамтад нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу тайлагнахыг;*

*[16] .Дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр байна.*

Аудитаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, холбогдох журмуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах талаар нийт 8 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

**МОНГОЛ УЛС**
**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн өргөн
чөлөө 3, Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101 Утас: (976) 70442273
Цахим шуудан: info@bayankhongor.gov.mn
Цахим хаяг: www.bayankhongor.gov.mn

2022.11.21 № 2/2038

танай ______________ -ны №______________-т

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ ТАНАА

"Аймгийн Баянхонгор аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн"-д гүйцэтгэлийн аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Мөн тайлангийн төслийг хэлтсийн дарга нарт танилцуулж ажилласан бөгөөд ямар нэг саналгүй байна.

ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ

652212712

D:\2022 он\Тамгын газар\Тамгын газар А5 тоот.docx

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймгийн ИТХ-аас 2017-2020 онд баталсан 34 дэд хөтөлбөрийг орон нутгийн хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, хуулийн заалтыг үндэслэсэн төлөвлөсөн ба эдгээрээс 21 дэд хөтөлбөр нь 2020 онд хэрэгжиж дуусан, 13 дэд хөтөлбөрийн хугацаа дуусаагүй хэрэгжиж байна.
2. Баталсан зарим төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжит үе шат, хугацаа, хариуцах эзэн, хамрах хүрээ, санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ зэргийг нарийвчлан төлөвлөөгүй байна.
3. Аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс нийт 4,661.0 сая төгрөгийн эх үүсвэрийг баталж, 4,377.8 сая төгрөгийг олгосон байна.
4. Зарим төсөл, хөтөлбөрийг батлахдаа хөтөлбөрийн шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүйгээс хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдсан эсэхийг тооцох боломжгүй байна.
5. Аймгийн ИТХ-аас дэд хөтөлбөрүүдийг батлахдаа аймгийн Засаг даргад хөтөлбөрт тусгагдсан зорилт, ажлуудыг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган биелэлтийг тайлагнаж байхыг даалгасан байхад хэрэгжүүлээгүй байна.
6. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд төсөл, хөтөлбөрүүдийн биелэлтийг аймгийн ИТХ-д иж бүрэн тайлагнаагүй байна.
7. Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж байгаа зөвлөмжид ямар албан тушаалтан хяналт-шинжилгээ үнэлгээг хэдий хугацаанд гүйцэтгэсэн, тайланг бичсэн огноо болон зөвлөмжийн биелэлтийг тайлагнах хугацааг бичээгүй, зөвлөмжийн биелэлтийг гаргуулан авч, биелэлтийг тооцож ажиллаагүй байна.
8. Аймгийн ИТХ-аас 2017-2020 онд баталсан дэд хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг хэрэгжсэн нийт хугацааны байдлаар тооцож ажиллаагүй байна.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**НЭГ. АЙМГИЙН ИТХ-Д ТОЛИЛУУЛАХ НЬ**

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийг баримт бичгийг төлөвлөхдөө Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5, 20 дугаар зүйлд заасны дагуу зорилго зорилт хэмжигдэхүйц, нөөц эх үүсвэрт үндэслэсэн, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан баримт бичгийг батлаагүй байна.
2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.8 дахь заалтыг хэрэгжүүлж, бодлогын баримт бичгийн хугацаа дуусахад нийт хэрэгжсэн хугацаагаар эцсийн үнэлгээ хийж, үр нөлөө, үр дүнг тооцохгүй байна.

**ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:**

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу хөгжлийн бодлогын баримт бичгийг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой тусган, хүрэх үр дүнг бодитой төлөвлөх
2. Аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж үр дүнг тооцож, биелэлтийг үнэн зөв бодитой тайлагнаж байх
3. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.8 дахь заалтыг хэрэгжүүлж, бодлогын баримт бичгийн хугацаа дуусахад нийт хэрэгжсэн хугацаагаар эцсийн үнэлгээ хийж, үр нөлөө, үр дүнг тооцож ажиллах
4. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд нийцүүлэн боловсруулж байх.
5. Хөгжлийн бодлогын баримт бичгийн биелэлтийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хугацаанд холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь тайлагнаж байх

**ГУРАВ. АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА Л.МАНДАЛ ТАНАА**

1. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангаар өгч байгаа зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх хугацааг тодорхой зааж, хэрэгжилтийг албан бичгээр авч, үр дүнг тооцож ажиллах

# ХАВСРАЛТУУД

## Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан байдал

Хавсралт 1

| | Хэрэгжүүлэгч байгууллага | Дэд хөтөлбөрийн нэр | № | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого | Үндэсний хөтөлбөр | Баянхонгор аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | Хуулийн заалттай нийцсэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | НБХ, ДЗОУБ | Хуримтлалтай хонгорчууд | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 69 дахь заалт | | | | |
| 2 | НБХ | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 65 дахь заалт | | | | |
| 3 | НБХ, Ахмадын хороо | Ахмадаа ачилья | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 57 дахь заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 3 | | | |
| 4 | ТЗУХ | Ухаалаг Баянхонгор | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 134 дэх заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 69 | | | |
| 5 | НБХ, БШУГ | Соёлын ажилтан | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 53 дахь заалт | | | | |
| 6 | НБХ, БШУГ | Баянхонгор робокон | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 16 дахь заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 3.1.1-зорилт-14 | | | |
| 7 | НБХ, БШУГ | Сайн багш | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 12 дахь заалт | | | | |
| 8 | НБХ, БШУГ | Хос бичигтэн | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 23 дахь заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 3.1.1-зорилт-4 | | | |

**Баянхонгор аймгийн ИТХ-аас 2016-2020 онд баталсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн**

| | Хэрэгжүүлэгч байгууллага | Дэд хөтөлбөрийн нэр | № | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого | Үндэсний хөтөлбөр | Баянхонгор аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | Хуулийн заалттай нийцсэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 9 | НБХ, БТСГ | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 46 дахь заалт | | | | |
| 10 | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | Торгон сүрэг | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 94 дэх заалт | | | | |
| 11 | ХБТХОХ, ХХААГ | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | | | "Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2" | | |
| 12 | ХБТХОХ, ХХААГ | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 67 дахь заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого 3.3 | | | |
| 13 | НБХ, ХХҮГ | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | | | "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй" үндэсний 5 дахь хөтөлбөр | | |
| 14 | НБХ, ХХҮГ | Залуучуудын хөгжлийг дэмжих | | | Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 | | |
| 15 | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | | |
| 16 | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | Илгээлтийн эзэн | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 104 дэх заалт | | | | |
| 17 | НХБ, ЭМГ | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 36 дах заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 28 | | | |
| 18 | НХБ, ЭМГ | Элэг бүтэн-Баянхонгор | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 28 дахь заалт | | | | |
| 19 | НХБ, ЭМГ | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | | | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | | |

| | Хэрэгжүүлэгч байгууллага | Дэд хөтөлбөрийн нэр | № | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого | Үндэсний хөтөлбөр | Баянхонгор аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | Хуулийн заалттай нийцсэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 20 | НХБ, ЭМГ | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 29 дэх заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 24 | | | |
| 21 | НХБ, ЭМГ | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | | | Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр | | |
| 22 | ХЭЗХ, ТАТ | Цахим архив Баянхонгор | | | Төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологид шилжүүлэх | | |
| 23 | НХБ, ЭМГ | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого-зорилт 3 | | | |
| 24 | ХБТХОХ, БОАЖГ | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 31 дэх заалт | | | | |
| 25 | НБХ, ГБХЗХГ | Хүүхдэд ээлтэй орон нутаг | | | Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хтөлбөр | | |
| 26 | ХЭЗХ, ТАТ | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 146 дахь заалт | | | | |
| 27 | ХБТХОХ, ЭХЗЗ | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 77 дахь заалт | | | | |
| 28 | ХБТХОХ, БОАЖГ | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | "Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 109 дэх заалт | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хэтийн зорилт | Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө 2030 | | |

| | Хэрэгжүүлэгч байгууллага | Дэд хөтөлбөрийн нэр | № | Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого | Үндэсний хөтөлбөр | Баянхонгор аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | Хуулийн заалттай нийцсэн |
|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 29 | НБХ, ГБХЗХГ | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | | | Жендерийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр | | |
| 30 | ХЭЗХ, ЦГ, | Амар тайван амьдрал | "Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 150 дэх заалт | | | | |
| 31 | СТХС | Тунгалаг санхүү | | | | Баянхонгор аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 90 дэх заалт | |
| 32 | ХЭЗХ, ЦГ, ГБХЗХГ | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | | | | | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль |
| 33 | ХЭЗХ, ЦГ | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | | | | | Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалт |
| 34 | ХЭЗХ, ТАТ | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | | | | | Архивын тухай хуулийн 19.1 дэх заалт |

**Дэд хөтөлбөрүүдийг шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон байдал**

Хавсралт 2

| ДД | Дэд хөтөлбөрийн нэр | Бүрэн хэрэгжиж зорилтод түвшинд хүрсэн дэд хөтөлбөр | Шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон ч зорилтод түвшиндээ хүрээгүй дэд хөтөлбөрүүд | Биелэлтийн тайланг гаргасан байгаа ч шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тооцоогүй дэд хөтөлбөрүүд | Шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүй дэд хөтөлбөрүүд | Биелэлтийг тооцох хугацаа болоогүй дэд хөтөлбөр |
|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Хуримтлалтай хонгорчууд | | | | 1 | |
| 2 | Тунгалаг санхүү | 1 | | | | |
| 3 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | 1 | | | | |
| 4 | Ахмадаа ачилья | 1 | | | | |
| 5 | Ухаалаг Баянхонгор | | 1 | | | |
| 6 | Соёлын ажилтан | | | | 1 | |
| 7 | Баянхонгор робокон | | | | 1 | |
| 8 | Сайн багш | | | | 1 | |
| 9 | Хос бичигтэн | | | | 1 | |
| 10 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | 1 | | | | |
| 11 | Торгон сүрэг | 1 | | | | |
| 12 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | 1 | | | | |
| 13 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | 1 | | | | |
| 14 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | | 1 | | | |
| 15 | Залуучуудын хөгжлийг дэмжих | | 1 | | | |
| 16 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | | | | 1 | |
| 17 | Илгээлтийн эзэн | 1 | | | | |
| 18 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | | | | 1 | |
| 19 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | | 1 | | | |
| 20 | Элэг бүтэн-Баянхонгор | | 1 | | | |
| 21 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | 1 | | | | |
| 22 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | | 1 | | | |
| 23 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | | 1 | | | |
| 24 | Цахим архив Баянхонгор | | | | 1 | |

| ДД | Дэд хөтөлбөрийн нэр | Бүрэн хэрэгжиж зорилтод түвшинд хүрсэн дэд хөтөлбөр | Шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг тооцсон ч зорилтод түвшиндээ хүрээгүй дэд хөтөлбөрүүд | Биелэлтийн тайланг гаргасан байгаа ч шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрсэн эсэхийг тооцоогүй дэд хөтөлбөрүүд | Шалгуур, зорилтыг үнэлэх суурь түвшин, хүрэх түвшнийг тоон болон чанарын үзүүлэлтээр илэрхийлж төлөвлөөгүй дэд хөтөлбөрүүд | Биелэлтийг тооцох хугацаа болоогүй дэд хөтөлбөр |
|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 25 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | 1 | | | | |
| 26 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | | | 1 | | |
| 27 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | | 1 | | | |
| 28 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | | | | 1 | |
| 29 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | | | 1 | | |
| 30 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | | | | | |
| 31 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | | | | | 1 |
| 32 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | | | | | 1 |
| 33 | "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах"аймгийн дэд хөтөлбөр | | 1 | | | |
| 34 | "Амар тайван амьдрал" дэд хөтөлбөр | | | | 1 | |
| | **Дүн** | **11** | **9** | **2** | **10** | **2** |

## Дэд хөтөлбөрүүдийн санхүүжилт /дэлгэрэнгүй/

Хавсралт 3

| № | Дэд хөтөлбөрийн нэр | 2017 он | | | 2018 он | | | 2019 он | | | 2020 он | | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | - | - | - | 10.0 | 7.3 | 2.7 | - | - | - | 7.0 | 6.9 | 0.1 | 17.0 | 14.24 | 2.76 |
| 2 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | - | - | - | - | - | - | - | - | - | 278.6 | 278.4 | 0.2 | 278.6 | 278.40 | 0.20 |
| 3 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | - | - | - | 8.0 | 7.8 | 0.2 | 4.0 | 4.0 | - | 4.0 | 4.0 | - | 16.0 | 15.82 | 0.18 |
| 4 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | - | - | - | 10.0 | 6.1 | 3.9 | - | - | - | - | - | - | 10.0 | 6.07 | 3.93 |
| 5 | Соёлын ажилтан | - | - | - | - | - | - | 88.9 | 88.8 | 0.0 | 3.0 | 3.0 | - | 91.9 | 91.85 | 0.00 |
| 6 | Баянхонгор робокон | - | - | - | - | - | - | - | - | - | 5.0 | 2.1 | 2.9 | 5.0 | 2.14 | 2.86 |
| 7 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | - | - | - | 120.0 | 120.0 | - | 210.1 | 210.1 | - | 349.1 | 349.1 | - | 679.1 | 679.15 | - |
| 8 | Тунгалаг санхүү | - | - | - | - | - | - | 9.0 | 9.0 | - | 10.0 | 9.6 | 0.4 | 19.0 | 19.59 | 0.41 |
| 9 | Сайн багш | - | - | - | 10.0 | 10.0 | 0.0 | 20.0 | 20.0 | - | 10.0 | 6.8 | 3.2 | 40.0 | 36.76 | 3.24 |
| 10 | Торгон сүрэг | 49.4 | 49.4 | - | 50.0 | 50.0 | 0.0 | - | - | - | - | - | - | 99.4 | 99.39 | 0.01 |
| 11 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | - | - | - | - | - | - | - | - | - | 90.0 | 90.0 | - | 90.0 | 90.00 | - |
| 12 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | - | - | - | - | - | - | - | - | - | 10.0 | - | 10.0 | 10.0 | - | 10.00 |
| 13 | Илгээлтийн эзэн | 330.0 | 330.0 | - | 340.0 | 340.0 | - | 495.0 | 495.0 | - | 100.0 | 100.0 | - | 1,265.0 | 1,265.00 | - |
| 14 | Ахмадаа ачилья | - | - | - | 10.0 | 10.0 | - | 3.0 | 3.0 | - | - | - | - | 13.0 | 13.00 | - |
| 15 | Ухаалаг Баянхонгор | - | - | - | 2.0 | 2.0 | - | 376.0 | 348.0 | - | - | - | - | 2.0 | 1.96 | - |
| 16 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | 560.0 | 560.0 | - | 400.0 | 400.0 | - | 681.0 | 681.0 | - | 873.0 | 673.0 | 200.0 | 2,514.0 | 2,314.00 | 200.00 |
| 17 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | - | - | - | - | - | - | 40.0 | 40.0 | - | - | - | - | 40.0 | 40.00 | - |
| 19 | Хос бичигтэн | - | - | - | - | - | - | - | - | - | 5.0 | 5.0 | - | 5.0 | 5.00 | - |
| 20 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | - | - | - | 14.7 | 14.7 | - | - | - | - | - | - | - | 14.7 | 14.65 | - |

| № | Дэд хөтөлбөрийн нэр | 2017 он | | | 2018 он | | | 2019 он | | | 2020 он | | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 21 | Залуучуудын хөгжлийг дэмжих | - | - | - | - | - | - | 4.8 | 4.8 | - | 5.0 | 4.7 | 0.3 | 9.8 | 9.44 | 0.34 |
| 22 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | - | - | - | 10.0 | 3.8 | 6.2 | 15.0 | 14.8 | 0.2 | 15.0 | 15.0 | 0.0 | 40.0 | 33.60 | 6.40 |
| 23 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | - | - | - | 432.5 | 432.5 | - | 1,300.0 | 1,300.0 | - | 19.0 | 19.0 | - | 1,751.5 | 1,751.50 | - |
| 24 | Элэг бүтэн-Баянхонгор | 43.2 | 43.2 | - | 61.2 | 61.2 | - | 172.6 | 172.6 | - | 6.5 | 6.5 | - | 283.5 | 283.50 | - |
| 25 | Цахим архив Баянхонгор | - | - | - | 70.0 | 70.0 | - | - | - | - | - | - | - | 70.0 | 70.00 | - |
| 26 | Хуримтлалтай хонгорчууд | - | - | - | 7.5 | 7.5 | - | - | - | - | 25.0 | 5.4 | 19.6 | 32.5 | 12.88 | 19.60 |
| 27 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | 2,634.0 | 2,633.8 | 0.2 | 3,920.7 | 3,920.7 | - | 5,889.9 | 5,889.5 | 0.4 | 4,620.0 | 4,620.0 | - | 17,064.6 | 17,064.04 | 0.60 |
| 28 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | - | - | - | 70.0 | 70.0 | - | 308.5 | 308.3 | 0.1 | 523.8 | 523.8 | - | 902.3 | 902.14 | 0.14 |
| 29 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | - | - | - | 41.0 | 40.9 | 0.1 | 203.5 | 203.5 | - | 370.9 | 367.9 | 3.0 | 615.4 | 612.35 | 3.08 |
| 30 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | - | - | - | - | - | - | 60.0 | 60.0 | - | 1,300.0 | 1,300.0 | - | 1,360.0 | 1,360.00 | - |
| 31 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 32 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 33 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | - | - | - | 5.0 | 4.6 | 0.4 | - | - | - | 3.0 | 3.0 | - | 8.0 | 7.59 | 0.41 |
| 34 | Амар тайван амьдрал | 34.9 | 34.9 | - | 10.0 | 10.0 | - | 9.5 | 9.5 | - | 74.3 | 73.3 | 1.0 | 128.7 | 127.65 | 1.00 |
| | **ДҮН** | **3,651.5** | **3,651.3** | **0.2** | **5,602.5** | **5,589.0** | **13.5** | **9,890.7** | **9,862.0** | **28.7** | **8,707.2** | **8,466.4** | **240.8** | **27,851.9** | **27,568.7** | **238.2** |

**Нягтлан бодох бүртгэлд тусгасан хөрөнгө**

Хавсралт 4

### А.Орон нутгийн хөрөнгө оруулалт

| ДД | Төсөл арга хэмжээний нэр | Мөнгөн дүн /сая төгрөг/ | Бүртгэсэн байгууллага |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 |
| 1 | Сурын талбайн тохижилт /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 135.5 | БТСГ |
| 2 | Баянхонгор сумын 5.6 дугаар багт өрхийн эмнэлэг барих /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 154.8 | ӨЭМТ |
| 3 | Хүчирхийллийн эсрэг төвийн Баянхонгор аймаг дахь салбарын 1 цэгийн үйлчилгээний төвийн байрны хашаажуулалтыг хийх /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 14.7 | ГБХЗХГ |
| 4 | Баянхонгор аймгийн Цахим мэдээллийн нэгдсэн системийг бий болгож "Ухаалаг Баянхонгор" хөтөлбөр хэрэгжүүлнэ. /Баянхонгор аймаг Баянхонгор сум/ | 70.0 | АЗДТГ |
| 5 | Баянхонгор сумын "Оточ мандал" өрхийн эмнэлгийн өргөтгөл, засварын ажил | 100.0 | ӨЭМТ |
| 6 | Баянхонгор сумын 7 дугаар багийн төвийн барилга барих /спорт заалтай/ /Баянхонгор аймаг. Баянхонгор сум/ | 199.0 | БТСГ |
| 7 | Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний автомашин /Баянхонгор аймаг. Баянхонгор сум/ | 25.0 | ГБХЗХГ |
| 9 | Цагдаагийн газрын POLICE READER төхөөрөмж | 19.9 | Цагдаагийн газар |
| 10 | Мотоцикл /Багийн эмч, сумын хэсгийн байцаагч/ | 68.0 | Цагдаагийн газар |
| 11 | Нэгдсэн эмнэлэг, моргт хөлдөөгч худалдан авах зардал | 19.9 | Нэгдсэн эмнэлэг |
| 12 | 1,4, 7,9 дүгээр багийн Өрхийн эмнэлгийн автомашин | 47.2 | ӨЭМТ |
| 13 | Соёлын төвийн техник хэрэгсэл /Бууцагаан, Баянцагаан, Шинэжинст, Гурванбулаг, Өлзийт/ | 35.9 | Соёлын төвүүд |
| 14 | Халдвартын эмнэлгийн агааржуулалт | 60 | Нэгдсэн эмнэлэг |
| 15 | Цагдаагийн газрыг нэн шаардлагатай автомашинуудаар хангах | 64.0 | Цагдаагийн газар |
| 16 | Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг эмнэлгийн үзлэг, үйлчилгээнд хамрагдахад зориулагдсан олон үйлдэлтэй техник, тоног төхөөрөмж худалдан авах | 6.9 | Нэгдсэн эмнэлэг |
| 17 | сервер | 17.7 | АЗДТГ |
| 18 | Эмнэлгийн тоног төхөөрөмж, | 12.4 | Нэгдсэн эмнэлэг |
| | **Дүн** | **1,050.8** | |

### Б. Улсын төсвийн хөрөнгө оруулалт

| ДД | **Төсөл арга хэмжээний нэр** | Мөнгөн дүн /сая төгрөг/ | Бүртгэсэн байгууллага |
|---|---|---|---|
| 1 | Бууцагаан, Галуут, Баян-өндөр зэрэг сумдын эрүүл мэндийн төвийн ариутгалын аппарат | 2.3 | Сумдын өрхийн эрүүл мэндийн төв |
| 2 | 900 мянган төгрөгийн өртөг бүхий хэргэгчийн хэм, хяналтын хэрэгсэл, зайнаас халуун хэмжигч багаж | 0.9 | Аймгийн өрхийн эрүүл мэндийн төв |
| 3 | Архивын барилга | 1,732.5 | Аймгийн ЗДТГ |
| | **Дүн** | **1,735.7** | |

**Дэд хөтөлбөрийн санхүүжилт /орон нутгийн төсөв/**

Хавсралт 5

| № | Дэд хөтөлбөрийн нэр | 2017 он | | | 2018 он | | | 2019 он | | | 2020 он | | | Нийт | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 1 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | - | - | - | 10.0 | 7.3 | 2.7 | - | - | - | 7.0 | 6.9 | 0.1 | 17.0 | 14.2 | 2.8 |
| 2 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | - | - | - | - | - | - | - | - | - | 278.6 | 278.4 | 0.2 | 278.6 | 278.4 | 0.2 |
| 3 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | - | - | - | 8.0 | 7.8 | 0.2 | 4.0 | 4.0 | - | 4.0 | 4.0 | - | 16.0 | 15.8 | 0.2 |
| 4 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | - | - | - | 10.0 | 6.1 | 3.9 | - | - | - | - | - | - | 10.0 | 6.1 | 3.9 |
| 5 | Соёлын ажилтан | - | - | - | - | - | - | 88.9 | 88.8 | 0.0 | 3.0 | 3.0 | - | 91.9 | 91.8 | 0.0 |
| 6 | Баянхонгор робокон | - | - | - | - | - | - | - | - | - | 5.0 | 2.1 | 2.9 | 5.0 | 2.1 | 2.9 |
| 7 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | - | - | - | 120.0 | 120.0 | - | 210.1 | 210.1 | - | 349.1 | 349.1 | - | 679.1 | 679.1 | - |
| 8 | Тунгалаг санхүү | - | - | - | - | - | - | 9.0 | 9.0 | - | 10.0 | 9.6 | 0.4 | 19.0 | 18.6 | 0.4 |
| 9 | Сайн багш | - | - | - | 10.0 | 10.0 | 0.0 | 20.0 | 20.0 | - | 10.0 | 6.8 | 3.2 | 40.0 | 36.8 | 3.2 |
| 10 | Торгон сүрэг | 49.4 | 49.4 | - | 50.0 | 50.0 | 0.0 | - | - | - | - | - | - | 99.4 | 99.4 | 0.0 |
| 11 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | - | - | - | - | - | - | - | - | - | 90.0 | 90.0 | - | 90.0 | 90.0 | - |
| 12 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | - | - | - | - | - | - | - | - | - | 10.0 | - | 10.0 | 10.0 | - | 10.0 |
| 13 | Илгээлтийн эзэн | 330.0 | 330.0 | - | 340.0 | 340.0 | - | 495.0 | 495.0 | - | 100.0 | 100.0 | - | 1,265.0 | 1,265.0 | - |
| 14 | Ахмадаа ачилья | - | - | - | 10.0 | 10.0 | - | 3.0 | 3.0 | - | - | - | - | 13.0 | 13.0 | - |
| 15 | Ухаалаг Баянхонгор | - | - | - | 2.0 | 2.0 | - | 376.0 | 348.0 | 28.0 | - | - | - | 378.0 | 350.0 | 28.0 |
| 16 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | 560.0 | 560.0 | - | 400.0 | 400.0 | - | 681.0 | 681.0 | - | 873.0 | 673.0 | 200.0 | 2,514.0 | 2,314.0 | 200.0 |
| 17 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 18 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | - | - | - | - | - | - | 40.0 | 40.0 | - | - | - | - | 40.0 | 40.0 | - |
| 19 | Хос бичигтэн | - | - | - | - | - | - | - | - | - | 5.0 | 5.0 | - | 5.0 | 5.0 | - |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | - | - | - | 14.7 | 14.7 | - | - | - | - | - | - | - | 14.7 | 14.7 | - |
| 21 | Залуучуудын хөгжлийг дэмжих | - | - | - | - | - | - | 4.8 | 4.8 | - | 5.0 | 4.7 | 0.3 | 9.8 | 9.4 | 0.3 |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 |
| 22 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | - | - | - | 10.0 | 3.8 | 6.2 | 15.0 | 14.8 | 0.2 | 15.0 | 15.0 | 0.0 | 40.0 | 33.6 | 6.4 |
| 23 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | - | - | - | 432.5 | 432.5 | - | 1,300.0 | 1,300.0 | - | 19.0 | 19.0 | - | 1,751.5 | 1,751.5 | - |
| 24 | Элэг бүтэн-Баянхонгор | 43.2 | 43.2 | - | 61.2 | 61.2 | - | 172.6 | 172.6 | - | 6.5 | 6.5 | - | 283.5 | 283.5 | - |
| 25 | Цахим архив Баянхонгор | - | - | - | 70.0 | 70.0 | - | - | - | - | - | - | - | 70.0 | 70.0 | - |
| 26 | Хуримтлалтай хонгорчууд | - | - | - | 7.5 | 7.5 | - | - | - | - | 25.0 | 5.4 | 19.6 | 32.5 | 12.9 | 19.6 |
| 27 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | 2,634.0 | 2,633.8 | 0.2 | 3,920.7 | 3,920.7 | - | 5,889.9 | 5,889.5 | 0.4 | 4,620.0 | 4,620.0 | - | 17,064.6 | 17,064.0 | 0.6 |
| 28 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | - | - | - | 70.0 | 70.0 | - | 308.5 | 308.3 | 0.1 | 523.8 | 523.8 | - | 902.3 | 902.1 | 0.1 |
| 29 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | - | - | - | 41.0 | 40.9 | 0.1 | 203.5 | 203.5 | - | 370.9 | 367.9 | 3.0 | 615.4 | 612.4 | 3.1 |
| 30 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | - | - | - | - | - | - | 60.0 | 60.0 | - | 1,300.0 | 1,300.0 | - | 1,360.0 | 1,360.0 | - |
| 31 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 32 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| 33 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | - | - | - | 5.0 | 4.6 | 0.4 | - | - | - | 3.0 | 3.0 | - | 8.0 | 7.6 | 0.4 |
| 34 | Амар тайван амьдрал | 34.9 | 34.9 | - | 10.0 | 10.0 | - | 9.5 | 9.5 | - | 74.3 | 73.3 | 1.0 | 128.7 | 127.7 | 1.0 |
| | **ДҮН** | **3,651.5** | **3,651.3** | **0.2** | **5,602.5** | **5,589.0** | **13.5** | **9,890.7** | **9,862.0** | **28.7** | **8,707.2** | **8,466.4** | **240.8** | **27,851.9** | **27,568.7** | **283.2** |

**Дэд хөтөлбөрүүдийн хамрах хугацаа**

Хавсралт 6

| № | Төсөл хөтөлбөрийн нэр | Хэрэгжүүлэгч байгууллага | Хэрэгжүүлэх хугацаа | Баталсан огноо | Тогтоолын дугаар | Хэрэгжиж дууссан хөтөлбөрүүд |
|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Хуримтлалтай хонгорчууд | СТСХ, ДЗОУБ | 2020-2024 он | 2020.07.31 | 59 | |
| 2 | Тунгалаг санхүү | СТХС | 2018-2020 он | 2019.03.19 | 23 | хэрэгжиж дууссан |
| 3 | Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхчүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах | НБХ | 2018-2020 он | 2018.07.07 | 81 | хэрэгжиж дууссан |
| 4 | Ахмадаа ачилья | НБХ, Ахмадын хороо | 2017-2021 | 2017.11.29 | 142 | хэрэгжиж дууссан |
| 5 | Ухаалаг Баянхонгор | ТЗУХ | 2017-2020 он | 2019.01.31 | 2 | Хэрэгжиж дууссан /цахим аймаг" хөтөлбөр шинээр хэрэгжиж байгаа |
| 6 | Соёлын ажилтан | НБХ, БШУГ | 2017-2020 он | 2017.07.17 | 104 | хэрэгжиж дууссан |
| 7 | Баянхонгор робокон | НБХ, БШУГ | 2017-2020 он | 2017.07.17 | 105 | хэрэгжиж дууссан |
| 8 | Сайн багш | НБХ, БШУГ | 2017-2020 он | 2017.07.17 | 106 | Хэрэгжиж дууссан /чадварлаг багш" хөтөлбөр шинээр хэрэгжиж байгаа |
| 9 | Хос бичигтэн | НБХ, БШУГ | 2017-2020 он | 2017.07.17 | 107 | хэрэгжиж дууссан |
| 10 | Үндэсний спортыг хэрэгжүүлэх | НБХ, БТСГ | 2017-2020 он | 2017.11.29 | 140 | хэрэгжиж дууссан |
| 11 | Торгон сүрэг | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2020 он, 2020-2025 он | 2017.05.16 | 76 | хэрэгжиж дууссан |
| 12 | Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр | ХБТХОХ, ХХААГ | 2020-2024 он | 2020.09.14 | 90 | |
| 13 | Баянхонгор аймгийн үйлдвэржилтийн нэгдсэн бодлого | ХБТХОХ, ХХААГ | 2019.01.31 | 2019.01.31 | 16 | |
| 14 | Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй | НБХ, ХХҮГ | 2018-2020 он | 2018.07.07 | 82 | хэрэгжиж дууссан |
| 15 | Залуучуудын хөгжлийг дэмжих | НБХ, ХХҮГ | 2017-2020 | 2018.09.19 | 106 | хэрэгжиж дууссан |
| 16 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2021 он | 2017.01.18 | 13 | |
| 17 | Илгээлтийн эзэн | ХБТХОХ, ХХҮГ, ХХААГ | 2017-2020 он | 2017.05.16 | 75 | хэрэгжиж дууссан |
| 18 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | ХЭЗХ, ЦГ, ГБХЗХГ | 2022-2023 он | 2020.08.26 | 71 | |
| 19 | Эрүүл мэндийн ажилтны хөгжил | НХБ, ЭМГ | 2017-2020 он | 2017.09.07 | 121 | хэрэгжиж дууссан |
| 20 | Элэг бүтэн-Баянхонгор | НХБ, ЭМГ | 2017-2020 он | 2017.11.29 | 143 | хэрэгжиж дууссан |
| 21 | Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого | НХБ, ЭМГ | 2017-2021 он, 2022-2026 он | 2017.11.29 | 144 | |
| 22 | Баянхонгорчууд бидний эрүүл мэндийн боловсрол | НХБ, ЭМГ | 2017-2020 он | 2017.11.29 | 145 | хэрэгжиж дууссан |
| 23 | Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах | НХБ, ЭМГ | 2018-2021 он | 2018.12.05 | 127 | |
| 24 | Цахим архив Баянхонгор | ХЭЗХ, ТАТ | 2020-2024 он | 2017.01.03 | 2 | |
| 25 | Эмэгтэйчүүдийн хөгжлийн дэмжих | НХБ, ЭМГ | 2017-2021 он | 2017.11.29 | 141 | |
| 26 | Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах | ХБТХОХ, БОАЖГ | 2017-2020 он | 2017.11.29 | 146 | хэрэгжиж дууссан |

| № | Төсөл хөтөлбөрийн нэр | Хэрэгжүүлэгч байгууллага | Хэрэгжүүлэх хугацаа | Баталсан огноо | Тогтоолын дугаар | Хэрэгжиж дууссан хөтөлбөрүүд |
|---|---|---|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 27 | Хүүхдэд ээлтэй орон нутаг | НБХ, ГБХЗХГ | 2017-2021 он | 2018.05.02 | 37 | хэрэгжиж дууссан |
| 28 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх | ХЭЗХ, ЦГ | 2017-2020 он | 2018.09.19 | 106 | хэрэгжиж дууссан |
| 29 | Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах | ХЭЗХ, ТАТ | 2018-2020 он | 2018.09.19 | 91 | |
| 30 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого | ХБТХОХ, ЭХЗЗ | 2019-2020 он | 2019.03.19 | 22 | |
| 31 | Баянхонгор аймгийн ногоон хөгжлийн хэтийн зорилт-2028 дунд хугацааны бодлогын баримт бичиг | ХБТХОХ, БОАЖГ | 2018-2023 он | 2018.03.05 | 10/1 | |
| 32 | Архив албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, удирдах болон гүйцэтгэх ажилтны мэдлэг ур чадварыг хөгжүүлэх | ХЭЗХ, ТАТ | 2024 он | 2020.02.01 | | |
| 33 | Жендерийн эрх тэгш байдлыг хангах | НБХ, ГБХЗХГ | 2018-2022 он | 2019.12.25 | 145 | хэрэгжиж дууссан /хугацааг сунгасан/ |
| 34 | Амар тайван амьдрал | ХЭЗХ, ЦГ, | 2017-2020 он | 2017.01.03 | 1 | хэрэгжиж дууссан |
| | *Дүн* | | | | | - |

---oOo---